МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2026 он

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025 оны 01 сарын 29-ний өдөр № .... Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 186 арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын 2.4-т заасан урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрээр үнэлгээ хийж, үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 186 арга хэмжээний биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар яамны газар, хэлтэс тус бүр хариуцсан ажил үүрэг, чиглэлийн дагуу тайлагнаж, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Нийт арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах үр дүнтэй байна. Үүнд:

- Үр дүн гараагүй буюу "0" хувиар үнэлгээ хийгдсэн 6 арга хэмжээ;
- Үр дүн хангалтгүй буюу "30-50" хувиар үнэлгээ хийгдсэн 52 арга хэмжээ;
- Үр дүн хүлээгдэж байгаа буюу "60-80" хувиар үнэлгээ хийгдсэн 24 арга хэмжээ;
- Үр дүнтэй буюу "90-100" хувиар үнэлгээ хийгдсэн 104 арга хэмжээ;

Нийт арга хэмжээний дундаж ***<u>74.6 хувьтай</u>*** буюу ***<u>"хангалттай"</u>*** үнэлгээ хийгдлээ.

*<u>Зураг1. Үнэлгээ хийгдсэн арга хэмжээ тус бүр нийт арга хэмжээнд эзлэх хувь</u>*



Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс үзэхэд 90-100 хувийн хэрэгжилттэй буюу хэрэгжилт хангалттай, үр дүнтэй дүгнэгдсэн 103 арга хэмжээ байгаа нь нийт үнэлгээ хийсэн 186 арга хэмжээний 55.9 хувийг эзэлж байна. Эдгээрээс зарим хэрэгжилтийг дурдвал:

1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын стратеги зорилтын 1-д "Харилцаа холбоо, инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын технологи, кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, урт болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, шаардагдах судалгаа шинжилгээ хийх, хөгжлийн бодлогын уялдааг хангах, бодлогын удирдамжаар хангах, хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх" төлөвлөлтийн хүрээнд туссан яамны зорилт 2 дахь арга хэмжээ буюу "Инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах" хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ 2.2-т "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж батлах" арга хэмжээний хэрэгжилт амжилттай хэрэгжсэн байна. Тодруулбал "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө"-ний анхны төслийг бэлтгэн холбогдох байгууллагуудаас санал авч, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 5 зорилт, 37 арга хэмжээтэйгээр төлөвлөгөөг баталсан гэжээ.

2. Яамны "Цахим засаглалын хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах" зорилт 3-ын хүрээнд туссан арга хэмжээ 3.3 "Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулах" ажлын биелэлт үр дүнтэй хэрэгжиж байна. Тодруулбал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын А/27 дугаар тушаалаар Ажлын дэд хэсгийн хурлын шийдвэрийн дагуу "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "e-Business"-д нэгтгэх" ажлын хүрээнд ажиллах төлөвлөгөө болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн "Ажил хариуцуулах тухай" тушаалыг боловсруулан батлуулж, 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/2379 тоот бичгээр холбогдох байгууллагуудад, 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 02/2412 тоот албан бичгээр харьяа байгууллагуудад тус тус хүргүүлсэн. Холбогдох байгууллагууд нь төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2025 оны 12 дугаар сарын байдлаар e-business платформд 832 үйлчилгээ нэвтэрсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна гэж тайлагнажээ.

3. Яамны "Салбарын урт, дунд болон богино хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах" зорилт 4-ийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг амжилттай хийж хэрэгжүүлсэн байна. Тодруулбал:

Арга хэмжээ 4.1. Монгол Улсын хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах төсөл арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд;

Арга хэмжээ 4.2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах төсөл, арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд;

Арга хэмжээ 4.3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулж,баталсан байна.

4. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны стратеги төлөвлөгөөний зорилт 2 "Нийтийн мэдээллийн дэд бүтцийг төрөөс иргэдэд үзүүлдэг үйлчилгээг дахин инженерчлэл хийх, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй хүргэхэд чиглүүлэн хөгжүүлэх" ажлын хүрээнд төлөвлөсөн яамны зорилт 1-д "Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх,

бизнес процессын дахин инженерчлэл хийх" ажлын явц үр дүнтэй хэрэгжиж байна. Тодруулбал:

Арга хэмжээ 1.5. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт боловсруулах ажлын биелэлтийг "Зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий 2022 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар баталсан. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг isr.gov.mn цахим системээр авч байна.

2025 онд нийт 18 зөвлөмжийг хүргүүлсэн. Жишээлбэл: Албан бичгээр Гадаадын иргэн, харьяатын газарт 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр, Зам тээврийн яаманд 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр, "system.gov.mn" системээр Ашигт малтмал газрын тосны газарт 2025 оны 02 дүгээр сарын 04-ний өдөр, Үндэсний статистикийн хороонд 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр, Төрийн орон сууцны корпорац ХХК-д 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Цагдаагийн ерөнхий газарт 2025 оны 09 дугаар сарын 10-ны өдөр, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 09 дугаар сарын 11-ний өдөр, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 09 дугаар сарын 11-ний өдөр мөн цахим шуудангаар буюу бусад хэлбэрээр Гадаадын иргэн, харьяатын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Улсын ерөнхий прокурорын газарт 2025 оны 12 дугаар сарын 04-ны өдөр, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд, Хууль зүйн туслалцааны төвд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр тус тус зөвлөмж гарган хүргүүлсэн болно" гэжээ.

Мөн арга хэмжээ 1.8-д "Шил ажиллагааны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчилах" ажлын биелэлтийг "Шил ажиллагааны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчилах хүрээнд Ажлын даалгаврыг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны "Штаб шинэчлэн байгуулах тухай" А/46 дугаар тушаалын дагуу Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран мэдээлэл хариуцагч байгууллага хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг ил тод байршуулсан эсэхэд Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан үнэлгээ өгөн, холбогдох заавар, мэдээллээр хангаж ажиллаж, нийт 3,980 байгууллагын 4,065 албан хаагчдад системийн хандах эрхийг олгож, 2,794 албан хаагчдыг сургалтад хамруулсан. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас нээлттэй мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор Монголын Үндэсний Олон нийтийн телевиз, "Ийгл" телевизүүдээр мэдээллийг хүргэн ажилласан" гэжээ.

5. Мөн стртеги зорилт 2-ын хүрээнд туссан яамны зорилт 3-т "Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөлт хийх, мэргэжил, арга зүй, технологийн шийдэл, удирдлагаар хангах" ажлын биелэлтүүд ахицтай байна.

Арга хэмжээ 3.1-д "Төрийн үйлчилгээг хиймэл оюуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий "Ухаалаг E-Mongolia" системийг хөгжүүлэх" ажил үр дүнтэй буюу "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ийн 5.0 хувилбарын хөгжүүлэлтийн хүрээнд Хиймэл оюунд суурилсан ухаалаг автомат хариулагчтай харилцах, Төрийн үйлчилгээний хөтөчөөр дамжуулан үйлчилгээгээ хялбар олох, хэтэвчээр дамжуулан төрийн үйлчилгээний төлбөр тооцоог төлөх, хэрэглэгч өөрийн тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй мэдээлэлэлтэй танилцах, судалгаанд оролцох, төрийн байгууллагаас хэлэлцүүлж буй хэлэлцүүлэгт санал өгөх зэрэг боломжуудыг бүрдүүлсэн. Мөн төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудастай холбож төрийн байгууллагаас ил тод нээлттэй байршуулахаар туссан 68 төрлийн мэдээллийг нэг дороос авах, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд системийг ашиглах зөвлөгөөгөөр

хангаж, хамгийн сүүлийн үеийн загвар дизайн бүхий системийг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр 1268 төрийн үйлчилгээг үзүүлж байна" гэжээ.

Мөн арга хэмжээ "Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программын нэгж лицензийн үнийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт хүргүүлэх" ажлыг Шадар сайдын Ажлын алба, ТЕГ-ын Мэдээллийн аюулгүй газар, ЗГХХГ, ТХААГ, ҮДТ, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/124 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02/1997 тоот бичгээр ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлэн, явцын тайланг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр, үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/2684 тоот бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралд танилцуулсан. Ажлын хэсгийн хүрээнд ЦХИХХЯ болон Майкрософт корпорацтай харилцан ойлголцлын санамж бичиг болон нууцлалын гэрээ байгуулах шийдвэрийг гаргаж, 2025 оны 12 дугаар сарын байдлаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг болон нууцлалын гэрээг байгуулсан. Ингэснээр дэвшилтэт технологи ба инновацаар дамжуулан төрийн дижитал шилжилтийг хурдасгаж, цахим эдийн засаг, цахим боловсролыг дэмжиж, оюуны өмчийн эрхийг хамгаалалтыг сайжруулан, өгөгдөл, мэдээллийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хадгалах дэд бүтэц ба кибер аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх хүрээнд нийт 12 зорилтыг хэрэгжүүлэх боломж бүрдсэн болно" гэж тус тус тайлагнасан байна.

Яамны стратегийн "Кибер аюулгүй байдлыг хангах асуудлыг нэгдсэн бодлого төлөвлөлтөөр хангах, хэрэгжилтийг зохион байгуулах" зорилт 5-ын дагуу төлөвлөсөн яамны зорилт 1 "Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах" ажлын биелэлт бүхэлдээ сайн үр дүнтэй байна. Тодруулбал:

- ➢ Арга хэмжээ 1.2."Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
- ➢ Арга хэмжээ 1.3. "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
- ➢ Арга хэмжээ 1.4. Тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийж, дүгнэлт гарган ажиллаж байна;
- ➢ Арга хэмжээ 1.5. Үндэсний хэмжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцооны суурь судалгаа хийх, аюулгүй байдлыг шалгах зааварчилгаа боловсруулсан;
- ➢ Арга хэмжээ 1.7. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт нөлөөллийн үнэлгээ хийсэн байна.

Түүнчлэн зорилтын дагуу хэрэгжилт үр дүнгүй үнэлгээ хийгдсэн зарим арга хэмжээг дараа онд дахин төлөвлөж үр дүнд хүргэх шаардлагатай байна. Үүнд:

- ❖ Арга хэмжээ 4.7. Үндэсний программ хангамжийн их дэлгүүр систем (Mindgolia) 2.0 хувилбарыг нэвтрүүлэх;
- ❖ Арга хэмжээ 2.6. Хиймэл оюунд суурилсан "Виртуал багш" системийг хөгжүүлэх;
- ❖ Арга хэмжээ 2.6. Үүрэн холбооны сүлжээ байгуулах /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дадал, Дархан, Баянмөнх, Баянхутаг сум/ төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;
- ❖ Арга хэмжээ 5.1. Сансрын тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах;
- ❖ Арга хэмжээ 5.10. MARS V төсөл цахим сургалт зохион байгуулах зэрэг болно.

Түүнчлэн нийт 186 арга хэмжээний 28 хувийг төсвийн тодотголтой холбоотойгоор ажил цааш үргэлжлээгүй, шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөгдсөн зорилтод хүрээгүй арга хэмжээнүүд ээлж байна. Үүнд:

- ▪ Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлэх;
- ▪ Интернэтийн дундын холболтын журмын төсөл боловсруулж, батлуулна.

▪ Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;

▪ Цахим эдийн засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах;

▪ Төрийн байгууллагуудад ашиглаж буй мэдээллийн технологийн шийдэл, системүүдийн нэгдсэн судалгаа хийж, зөвлөмж боловсруулах;

▪ Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулах;

▪ "Тусгай дугаар 112"-ын үйл ажиллагаанд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийг судалгаа хийх;

▪ Камерын хяналтын нэгдсэн систем бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмжийн нөхцөл шаардлагыг тодорхойлох суурь судалгаа хийж стандартын төсөл боловсруулах;

▪ Цахим шилжилтийг салбар бүрд эрчимжүүлэхэд тухайн салбарын талаарх хөндлөнгийн анализ бүхий материал, нэвтрүүлэг, контент хийх;

▪ "Дижитал-Аймаг, Дижитал-Хот" зөвлөмжийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах;

▪ Шүүхийн салбарын цахим шилжилт төслийг хэрэгжүүлэх суурь судалгаа хийж зөвлөмж боловсруулах;

▪ Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

▪ Сэлгэн ажиллах /high availability/ дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгох;

▪ Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-ийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх;.

▪ Олон нийтийн байгууллагуудын засаглалыг дэмжих нээлттэй платформ хөгжүүлэх;

▪ Авто ослын баримтжуулалтын систем (ослын баримт баталгаажуулалтын платформ) хөгжүүлэх;

▪ Иргэн гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан нийгмийн оролцоогоо хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх "Иргэний хяналт" платформ хөгжүүлэх;

▪ "Токенжуулсан хувьцаа" төслийг боловсруулах;

▪ Албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

▪ Сонсголын бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хиймэл оюуны хөрвүүлэгч систем нэвтрүүлэх;

▪ Тусгай хэрэгцээт иргэдийн цахим ур чадварыг сайжруулах сургалтыг зохион байгуулах;

▪ Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;

▪ Инновац, мэдээллийн технологийн паркийн талаар судалгаа хийж, цаашид баримтлах бодлогыг боловсруулж, бүс, орон нутагт парк байгуулахад тавигдах шаардлагыг тодорхойлох;.

▪ Нисгэгчгүй нисэх төхөөрөмж буй дрон жолоодлогын Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах;

▪ Монгол улсын инновацын тогтолцооны гүйцэтгэлийг үнэлэх олон улсын судалгааны аргачлалыг нутагшуулж, мэдээллийн технологийн болон өндөр технологийн салбарт инновацын судалгаа хийх;

▪ Инновацыг шинэ санааг хөгжүүлэх бүх насны иргэдэд зориулсан 10 цуврал контент хийх;

▪ Салбарын судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг хангах, тэдний чанарыг сайжруулах зорилгоор цалинтай PhD доктор хөтөлбөрийг боловсруулах;

▪ Өгөгдлийн хакатон зохион байгуулах;

▪ МХХТ-ийн салбарын бизнес эрхлэгч, гарааны бизнесүүдэд ээлтэй, хууль, эрхзүй, санхүүгийн тогтвортой орчныг бүрдүүлэх "Business friendly Mongolia" хөтөлбөр боловсруулах;

▪ Өндөр хөгжилтэй орнуудын гарааны бизнес, хөрөнгө оруулалт, өндөр технологи, инновацын талаарх шинэ мэдлэг, мэдээлэл, ноу-хау импортлох, нутагшуулах ажлыг зохион байгуулах;

▪ Гарааны бизнес, инновацын талаар мэдлэг, соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах;

▪ Улс хоорондын транзит урсгалыг нэмэгдүүлэх, шинэ гарц бий болгох эрх зүйн зохицуулалт, зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа хийх;

▪ IoT (Internet of Things) болон Digital twin технологийг нэвтрүүлэх судалгаа хийнэ.

▪ Харилцаа холбооны салбарын (мобайл станц, шилэн кабель, шуудан) нэгдсэн дата бааз байгуулах, real time AI-д суурилсан систем нэвтрүүлэх;

▪ Харилцаа холбооны цамхгийн металл хийцийн ядралын зэрэг тогтоох, үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулах /Харилцаа холбооны дэд бүтцийн хэвийн найдвартай ажиллагааг хангах/;

▪ Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-ийг шинэчлэн боловсруулах;

▪ Кибер халдлага, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх систем хөгжүүлэх тооцоо судалгаа хийх, системийг нэвтрүүлэх;

▪ Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилэх;

▪ Тоон гарын үсгийг олон улсад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх төслийг эхлүүлнэ.

▪ Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, хадгалах технологид тавигдах шаардлагын төслийг боловсруулж, батлах;

Дээрх үр дүнд суурилж дараах хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийг гаргаж байна.

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс харахад яам нь салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн чиглэлээр тодорхой ахиц дэвшил гаргаж, стратегийн зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд бодитой анхаарч ажилласан нь харагдаж байна. Нийт 186 арга хэмжээнээс 103 арга хэмжээ 90–100 хувийн хэрэгжилттэй үнэлэгдэж, нийт гүйцэтгэлийн дундаж 74.6 хувьтай буюу “хангалттай” түвшинд хүрсэн нь байгууллагын үйл ажиллагаа тогтвортой, үр дүн чиглэсэн байдлаар хэрэгжсэнийг илтгэж байна.

Тодруулбал цахим засаглал, төрийн үйлчилгээний дижитал шилжилт, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан, инновац, кибер аюулгүй байдлын чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулах, систем нэвтрүүлэх, институц хоорондын уялдааг сайжруулах чиглэлд бодит үр дүн гарсан нь онцлох амжилт боллоо. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ийн шинэчилсэн хувилбар, e-Business платформын өргөжилт, нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тогтолцоог бэхжүүлсэн нь иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чухал хувь нэмэр оруулсан байна.

Мөн салбарын дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж баталсан, үндэсний хэмжээний зөвлөл, ажлын хэсгүүдийг байгуулан бодлогын хэрэгжилтийг зохион байгуулсан нь салбарын хөгжлийг цогцоор нь харсан, тогтвортой бодлогын суурийг бүрдүүлсэн эерэг алхам боллоо. Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд журам, аргачлал, аудит, эрсдэлийн үнэлгээ, нөлөөллийн үнэлгээ хийсэн нь үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах чадавхыг бэхжүүлэхэд бодит ахиц авчирсан байна.

Түүнчлэн яамнаас хэрэгжүүлж буй олон арга хэмжээ нь бусад яам, агентлаг, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжиж байгаа нь салбар

дундын уялдаа холбоо сайжирч, бодлогын хэрэгжилт илүү бодит, өргөн хүрээтэй болж байгааг харуулж байна. Хэдийгээр зарим арга хэмжээ төсөв, төлөвлөлттэй холбоотой шалтгаанаар бүрэн хэрэгжээгүй ч тэдгээрийг дараагийн жилүүдэд дахин төлөвлөн хэрэгжүүлэх боломж, суурь нөхцөл бүрдсэн гэж үзэх үндэслэлтэй.

Ерөнхий дүгнэлтээр Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам нь 2025 онд салбарын бодлогын залгамж чанарыг хадгалж, цахим шилжилт, инноваци, технологийн хөгжлийг дэмжих чиглэлээр бодит үр дүнд хүрсэн бөгөөд цаашид төлөвлөлт, хэрэгжилтийн уялдааг сайжруулснаар илүү өндөр үр ашиг, тогтвортой хөгжлийг хангах бүрэн боломжтой байна.

Гэсэн хэдий ч хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх явцад төлөвлөлттэй холбоотой хэд хэдэн асуудал байна гэж үзлээ. Тодруулбал байгууллагын төлөвлөгөөний хугацаа хэсэгт хэт ерөнхий буюу 1-4 дүгээр улиралд гэж бичснээс шалтгаалж улирал тус бүрд хийж хэрэгжүүлэх ажил тодорхойгүй байдал үүссэн гэж дүгнэж байна.

Мөн төлөвлөгөөний биелэлтийг ирүүлж буй албан хаагчид хэт их үгийн товчлол хэрэглэсэн, 2000 тэмдэгтээс хэтэрсэн, хэрэгжилтийн агуулгыг бүрэн илэрхийлж чадаагүй гэх зэрэг асуудлууд байна. Өөрөөр хэлбэл зарим арга хэмжээг хэдий 100 хувиар үнэлгээ хийсэн боловч нэгэнт төлөвлөсөн зорилттоо хүрсэн бол ямар үр дүнд хүрсэн талаар тайлагнах ёстой боловч тайланд зөвхөн жижиг процессын шатны агуулгыг дурдсан нь үндсэн зорилтдоо хүрснийг бүрэн илэрхийлж чадахгүй байна.

Түүнчлэн байгууллагын төлөвлөгөөний суурь түвшинг тодорхой тавиагүй нь арга хэмжээний үнэлгээг бодитоор тооцоход хүндрэл үүсгэсэн болно.

Мөн сайдын стратеги зорилтоос 8 зорилтыг тус яам хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байх ба эдгээр 8 зорилтод нийцүүлж газар хэлтсийн төлөвлөгөө туссан боловч, нэгтгэл хийсэн биелэлтээс аль газар хэлтэс аль арга хэмжээг тайлагнасан, хүний нөөцийн хувьд тухайн газар, хэлтэс хангалттай байгаа эсэх, төлөвлөсөн зорилтыг хэрэгжүүлэх нөөц бололцоо байсан эсэхэд дүгнэлт хийхэд саад учирсан гэж үзлээ.

Өөрөөр хэлбэл яамны төлөвлөгөөний хэдэн хувийг аль газар хариуцан ажиллаж байгаа талаарх үр дүнгийн тусламжтай тухайн бодлогыг хэрэгжүүлэх хүний нөөцийн асуудлыг хөндөж удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх боломжтой байсныг онцолж байна.

Дээрх асуудлуудаас гадна албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хамаарах нотлох баримт өгөөгүй нь үнэлгээний оноог бууруулахад нөлөөллөө.

Мөн 2025 оны эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд нийт арга хэмжээний 30 гаруй хувь хангалтгүй байгаа нь төлөвлөлтийг оновчтой, тодорхой хийж чадаагүй байна. Жишээлбэл 30 хувиар үнэлгээ хийгдсэн арга хэмжээнүүдийн дийлэнх нь Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан төсөвгүй болж цаашид үргэлжлэх боломжгүй ажлууд бичигдсэн байх ба ажлын даалгаврыг эртнээс батлуулж, худалдан авах ажиллагааг зарлаагүйтэй холбоотойгоор хэрэгжээгүй гэж үзэх үндэслэл бүрдсэн байна.

Мөн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн оны 5 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулсан арга хэмжээ цөөн байлаа. Зарим арга хэмжээнүүдийн хувьд 5 дугаар сард багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан гэх боловч оролцогчгүй эсхүл шаардлага хангасан оролцогч орж ирээгүй гэх шалтгаанаар худалдан авах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. Шаардлага хангасан оролцогч байгаагүй худалдан авах ажиллагааны тухайд ажлын даалгавар, техник эдийн засгийн үндэслэлийг зөв тодорхойлж, оролцогч орж ирэх шалтгаан нөхцлийг бодитоор тусгасан эсэх нь тодорхойгүй байна.

Түүнчлэн яамны газар хэлтсүүд тайланд бодитоор хандаж, биелэлтийг албан хаагчийн зүгээс бус яам дээд газарт тайлагнаж буй хэлбэрээр тайлагнах шаардлагатай. Тодруулбал байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах албан хаагчийн нэр хэсэгт Төсвийн шууд захирагч буюу Төрийн нарийн бичгийн дарга байхаар туссан байдаг. Гэтэл биелэлт дунд "...яам нэгж хоорондоо хүргүүлсэн, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан, тайлагнасан" гэх мэт агуулгаар Төсвийн шууд захирагчийн зүгээс бус албан хаагч өөрийн зүгээс тайланг

бэлтгэсэн байна. Иймд тайланд уншилт хийх явцад хэлбэрийн өөрчлөлтийг салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас засаж сайжруулсан болно.

Мөн нэгтгэл хийж буй албан хаагчид "Excel" формат ашиглаж хүснэгтэн нэгтгэлийг хийгээгүй, тайланг уншиж утга агуулга, хэлбэрийн шаардлагыг засаагүй, удирдлагаар хянуулахгүйгээр ирүүлснээс үүдэлтэй тайланд уншилт хийх явцыг удаашруулсан болно.

Иймд дээрх шалтгаануудыг үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна.

## ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Хэрэгжилт хангалтгүй, үр дүнг хангалттай тайлагнаж чадаагүй ажлуудыг 2025 оны сүүлийн хагас жилд эрчимжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Яамны бодлого төлөвлөлтийн болон бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад:

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хугацаа, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох;

Цаашид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа арга хэмжээ бүрийн хэрэгжих хугацааг улирал, сар, үе шаттайгаар нарийвчлан тодорхойлж, хүрэх эцсийн үр дүн, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгах шаардлагатай. Ингэснээр хэрэгжилтийн явцыг бодитой үнэлэх, улирал тутам хяналт-шинжилгээ хийх боломж сайжирна.

2. Суурь түвшнийг тодорхойлж хэвших;

Арга хэмжээ бүрийн эхлэх үеийн суурь түвшинг тодорхой заагаагүйгээс үнэлгээ бодитой хийгдэхэд хүндрэл үүсэж байна. Иймд цаашид төлөвлөлт хийхдээ тухайн арга хэмжээ хэрэгжихээс өмнөх нөхцөл байдал, тоон болон чанарын суурь үзүүлэлтийг заавал тогтоож, түүнд тулгуурлан ахиц, үр дүнг хэмжих шаардлагатай.

3. Тайлангийн агуулга, хэлбэрийн нэгдсэн стандартыг мөрдүүлэх;

Гүйцэтгэлийн тайлан гаргаж буй албан хаагчид товчлол хэтрүүлэн хэрэглэх, агуулга давхардсан, 2000 тэмдэгтээс хэтэрсэн, бодит үр дүнг бүрэн илэрхийлээгүй тайлагнал ирүүлж байгаа нь ажиглагдаж байна. Иймд тайлан бичих загвар, үгийн тоо, агуулгын шаардлагыг нэг мөр болгож, хэрэгжилтийн эцсийн үр дүнг тодорхой тайлагнах нь зүйтэй.

4. Төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг эртнээс оновчтой хийх;

Төсвийн тодотгол, худалдан авах ажиллагаа оройтсонтой холбоотойгоор олон арга хэмжээ хэрэгжээгүй байна. Иймд ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг оны эхэнд батлуулж, худалдан авах ажиллагааг 5 дугаар сарын 01-ний дотор багтаан зохион байгуулах, зах зээлийн судалгааг бодитой хийх замаар хэрэгжилтийг хангах шаардлагатай.

5. Газар, хэлтсийн оролцоо, хариуцлагын уялдааг тодорхой болгох;

Яамны стратеги зорилтод нийцүүлэн газар, хэлтсийн хариуцах арга хэмжээ, хүний нөөцийн чадавх, ажлын ачааллыг тодорхой тусгаагүйгээс нэгтгэл дүгнэлт хийхэд хүндрэл үүссэн. Иймд цаашид аль газар, хэлтэс ямар арга хэмжээг хариуцан хэрэгжүүлж буйг тодорхой тусгаж, хариуцлага, тайлагналын уялдааг сайжруулах нь зүйтэй.

6. Яамны төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ахиулахтай холбоотой нэгжийн удирдлагууд хяналт тавьж ажиллах;

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах, ирэх онд хэрхэн зөв төлөвлөх талаар талаар яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

-оОо-

## ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
## 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Зарцуулсан төсөв /сая/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилт от түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Яамны стратегийн зорилт 1. Харилцаа холбоо, инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын технологи, кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, урт болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, шаардагдах судалгаа шинжилгээ хийх, хөгжлийн бодлогын уялдааг хангах, бодлогын удирдамжаар хангах, хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх | | | | | | | |
| Зорилт 1. Харилцаа холбоо, шуудан, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана. | | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо<br>Батлуулсан баримт бичгийн тоо | 0<br>0 | 3<br>4 | Боловсруулсан баримт бичгийн тоо-3<br>Хүргүүлсэн баримт бичгийн тоо-1<br>Төсөв татагдсан тул хэрэгжүүлэх боломжгүй болсон-2 | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн хуулийн төслийн тоо | 0 | 1 | Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг 2024 оны 11 дүгээр сард Сайдын орон тооны бус зөвлөхөөр ахлуулан байгуулсан ч яамны зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Ажлын хэсгээс шийдвэр гараагүй байна. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулсан. | 30 |
| 2 | Арга хэмжээ 1.2. Шуудангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн хуулийн төслийн тоо | 0 | 1 | Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/73 дугаартай сайдын тушаалаар байгуулсан. Тус ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр болон 05 дугаар сарын 16-ны өдрүүдэд Улсын Их Хурлын Инновац цахим бодлогын байнгын хороонд Шуудангийн тухай хуулийн хэрэгжилт болон тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар мэдээлэл хийсэн. Мөн шуудангийн үйлчилгээ үзүүлэгч оролцогч талуудаас хуульд нэмэлт өөрчлөлтөд оруулах санал болон Шуудан, цахим худалдааны бодлого, зохицуулалтын үйл ажиллагаанд тусгах санал авахаар шуудангийн үйлчилгээ үзүүлэгч 24 байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1278 дугаартай | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан бичиг хүргүүлэн саналыг хүлээн авч ажиллаж байна. Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2024 онд хийсэн үнэлгээгээр уг хуулийг шинэчлэн найруулах практик хэрэгцээ, шаардлага үүссэн гэж дүгнэсэн бөгөөд хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг төрийн болон хувийн хэвшлийн, холбогдох мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдүүлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/152 дугаар тушаал батлагдсан. | |
| 3 | Арга хэмжээ 1.3. Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколыг соёрхон батлахтай холбоотой материалыг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколын үзэл баримтлалын төсөл батлуулахад шаардагдах үр нөлөө болон холбогдох судалгааг хийсэн. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколын үзэл баримтлалын төслийг боловсруулж Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Гадаад харилцааны сайдаар батлуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/2539 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | 70 |
| 4 | Арга хэмжээ 1.4. Интернэтийн дундын холболтын журмын төсөл боловсруулж, батлуулна. | - | Батлуулсан баримт бичгийн тоо | Судалгаа | 1 | Интернэтийн дундын холболтын журам боловсруулах хүрээнд ажлын даалгавар баталсан. Уг ажлыг нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгүүлэхээр холбогдох мэдээллийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 02/1361 дугаар албан бичгийг Нат Си Икс Экспертс ХХК, Мэдээлэл холбооны чадавхын хөгжлийн форум ТББ, Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци ТББ-д тус тус хүргүүлэв. Төсөв татагдсан тул хэрэгжүүлэх боломжгүй болсон. | 30 |
| 5 | Арга хэмжээ 1.5. Монгол Улсын Харилцаа холбооны дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж, батлуулна. | - | Батлуулсан баримт бичгийн тоо | 1 | 1 | 1. Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг улсын хэмжээнд “112” дугаараар хүлээн авахад шаардлагатай техникийн нөхцөл, системийн тохиргоог үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийг оролцуулан зохион байгуулах, нэгдсэн дугаарлалтад шилжих системийг нийтийн мэдээллийн дэд бүтцэд нийцүүлэн боловсруулах, хиймэл оюунд суурилсан технологийн шийдлийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдийн А/43 дугаар тушаалаар байгуулсан.<br>2. Авлигатай тэмцэх газраас Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой тодруулга авах хүсэлтийн дагуу АТГ болон ХХЗХ-ны холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр уулзалт зохион байгуулсан. Мөн нэмэлт мэдээлэл бэлтгэж, /byambadorj@jaac.mn/ цахим шуудангаар хүргүүлсэн. | |
| | | | | | | 3.ЦХИХХ-ны сайдын 2024 оны А/29 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаар болон Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт (Toll free)-ын ялгаа, зааг болон Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан зөвлөмж /ITU-T E.161.1/-ийн талаар мэдээлэл өгч, санал солилцсон. | |
| 6 | Арга хэмжээ 1.6. Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи нэвтэрч байгаатай холбогдуулан 2G, 3G технологид суурилсан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулна. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи нэвтэрч байгаатай холбогдуулан 2G, 3G технологид суурилсан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтнуудын саналыг тусган, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/45 дугаар тушаалаар баталж, ажлын хэсгийн хурлыг 2025 оны 03 дугаар сарын 17, 05 дугаар сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулав. Судалгаанд үндэслэн хөдөлгөөнт холбооны 2G болон 3G сүлжээг зогсооход баримтлах чиглэлийн төсөл боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан. | 80 |
| **Зорилт 2. Инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун хөгжлийн бодлого, хууль,** | | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0<br>0 | 1<br>2 | **Баталсан баримт бичиг 1** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана. | | Боловсруулсан баримт бичгийн тоо | | | | |
| 7 | Арга хэмжээ 2.1. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. | - | Судалгааны тоо<br>Хүргүүлсэн хуулийн төслийн тоо | 0<br>0 | 1<br>1 | Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах" ажлын даалгаврыг баталсан. Уг тендерийг зохион байгуулах Үнэлгээний хороог 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан. Тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 21 болон 05 дугаар сарын 29-ний өдөр тус тус зарласан ч амжилтгүй болсон. Төсвийн тодотголоор төсөв татагдсантай холбоотой уг ажил зогссон болно. | 30 |
| 8 | Арга хэмжээ 2.2. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж батална. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль | 1 | Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичиг болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан Засгийн газрын 2020 оны 100 дугаар тогтоолоор баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө"-ний анхны төслийг бэлтгэн холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 5 зорилт, 37 арга хэмжээтэй стратеги төлөвлөгөө батлагдсан. | 100 |
| | Зорилт 3. Цахим засаглалын хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана. | - | Хүргүүлсэн тоо<br>Боловсруул тоо<br>Арга хэмжээний тоо | 0<br>0<br>0 | 2<br>2<br>1 | Боловсруулж байгаа баримт бичгийн тоо-3<br>"license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 44, эрх бүхий байгууллага өөрийн системээр 123 зөвшөөрөл | |
| 9 | Арга хэмжээ 3.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийг | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | Дэлхийн ДНБ-ний 80%, ОУ-ын худалдааны 75%, Дэлхийн хүн амын гуравны хоёр (2/3), Дэлхийн газар нутгийн 60%-ийг эзэлдэг G7, G20-д багтдаг Европын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. | | | | | холбооны гишүүн 40-өөд улсын мөрддөг баримт бичиг болох:<br>• Европын харилцан уялдааны тогтолцооны архитектур<br>• Европын харилцан уялдааны тогтолцоо<br>• Европын харилцан уялдааны тогтолцооны лавлагаа<br>• Европын цахим эрх ба зарчим<br>• Европын харилцан уялдааны архитектурыг хөгжүүлэх үйл ажиллагаа<br>• Эстони Улсын X-Road системийн тухай<br>• Европын дижитал 10 жилийн хөтөлбөр(The European Digital decade program-2030)<br>• Олон Улсын эдийн засаг, хөгжлийн агентлагаас гаргасан Цахим засаглалын бодлогын хүрээ зэрэг баримт бичгүүдийг судалсан.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем болон мэдээллийн сүлжээ, нийтийн мэдээллийн сангийн хэрэглээ, түүний ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн зураглалыг гаргаж, нэгдсэн зөвлөмж, заавар боловсруулах зорилготой тендерийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг тус тус боловсруулж, уг тендерийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан боловч, оролцогч орж ирээгүй.<br>Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/319 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулан уг журмын төслийг боловсруулж байна. | |
| 10 | Арга хэмжээ 3.2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/319 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулан журмын төслийг боловсруулж байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын А/27 дугаар тушаалаар Ажлын дэд хэсгийн хурлын шийдвэрийн дагуу "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "e-Business"-д нэгтгэх" ажлын хүрээнд ажиллах төлөвлөгөө болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн "Ажил хариуцуулах | |
| 11 | Арга хэмжээ 3.3. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулна. | - | Цахим хэлбэрт шилжүүлсэн зөвшөөрлийн тоо | 0 | 1 | тухай" тушаалыг боловсруулан батлуулж, 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/2379 тоот бичгээр холбогдох байгууллагуудад, 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 02/2412 тоот албан бичгээр харьяа байгууллагуудад тус тус хүргүүлсэн. Холбогдох байгууллагууд нь төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2025 оны 12 дугаар сарын байдлаар e-business платформд 832 үйлчилгээ нэвтэрсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна. | 100 |
| 12 | Арга хэмжээ 3.4. Нотариатын үйл ажиллагааг үе шаттай сайжруулна. | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 0 | 1 | Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд цахим гэрээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх (нотариат) судалгаа" ЦХИХХЯ/20250203039 дугаар төслийн ажлыг Төрийн нарийн бичгийн даргын "Үнэлгээний хороо байгуулж, зардал гаргах тухай" 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/146 дугаар тушаалаар баталсан боловч төсөв татагдсан.<br>Нотариатын тухай хуульд зайн гэрчлэлтийн талаарх зохицуулалтыг тусгахаар 2 удаагийн уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар 2022 онд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нотариатчидын танхимтай хийсэн хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг шинэчлэн байгуулж, нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахим хэлбэрт шилжүүлэх болсон ба "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 54-т Нотариатын тухай хуулийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлэлцэх тов тусгагдсан. 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар дээр дурдсан "Санамж бичиг"-ийн төслийг боловсруулж, албажуулах ажил хийгдэж байна. | |
| 13 | Арга хэмжээ 3.6. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсүүдэд, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарынхны дунд зөвлөгөөн зохион байгуулна. | - | Зохион байгуулсан зөвлөгөөний тоо | 0 | 1 | Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны үеэр бүсийн цахим шилжилт, өндөр технологи нэвтрүүлэлтийн салбар хуралдааныг яамны чиг үүргийн хүрээнд:<br>1.Салбарын зорилтыг бүсийн хөгжилтэй уялдуулан бүс, орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 мега төслийн саналыг нэгтгэн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/941 дугаар албан бичгээр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв.<br>2."Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан-2025" бүсийн салбар хуралдааны хэлэлцүүлгийн агуулгыг бэлтгэн Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газарт 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлэв.<br>3.Говийн болон Төвийн бүсийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал тусган 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/1186, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1324, 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 01/1996 албан бичгээр Монгол Улсын шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв. | 100 |
| **Зорилт 4. Салбарын урт, дунд болон богино хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулна.** | | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо<br>Боловсруулсан баримт бичгийн тоо | 0<br>0 | 2<br>2 | **Хүргүүлсэн баримт бичгийн тоо-2**<br>**Боловсруулсан баримт бичгийн тоо-2** | |
| 14 | Арга хэмжээ 4.1. Монгол Улсын хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах төсөл арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төсөлд нийт 8 бүлэг асуудлын хүрээнд ТЕЗ-ийн түвшний 9, хөлбөрийн түвшний 21 ажлын үр дүн, арга замыг тодорхойлж хүргүүлсэн ба тус яам хариуцан хэрэгжүүлэх 11, хамтран хэрэгжүүлэх 7 ажил тусч, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр УИХ-аар батлагдсан.<br>Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т "Хөгжлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ. | | | | | бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ." гэж заасны дагуу Эдийн засаг хөгжлийн яамнаас 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд Хүний хөгжил, Нийгмийн хөгжил, Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, Байгаль орчин, Засаглал, Бүсийн хөгжил, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гэсэн сэвүүдийн хүрээнд үндэсний үр дүнг тооцох хэлэлцүүлэг санал боловсруулж, оролцсон ба "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2026-2030"-д тусгах шинжлэх ухаан, технологийн бүлгийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 09-р сарын 25-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт нийт 45 байгууллагын төлөөлөл оролцож, санал, зөвлөмж өгсөн. | |
| 15 | Арга хэмжээ 4.2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах төсөл, арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | Монгол Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 48 дугаар тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө" батлагдсан ба тус яамнаас нийт 25 төсөл, арга хэмжээний санал боловсруулж, хүргүүлснээс 12 төсөл, арга хэмжээг дэмжин баталсан. | 100 |
| 16 | Арга хэмжээ 4.3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулж,батална. | - | Батлуулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалаар баталсан. Стратеги төлөвлөгөөг боловсруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:<br>1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өнөөгийн байдал, стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлага, мандатын шинжилгээ, орчны шинжилгээг хийж, зорилго зорилтуудыг тодорхойлсон.<br>2.ЗГҮАХ 2024-2028-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн олон улсын индексүүдийн 2024 оны үзүүлэлтүүдийг судалж, зорилтод түвшнийг тодорхойлон холбогдох тайлбаруудыг оруулсан. | |
| **Зорилт 5. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүний нөөцийн бодлого боловсруулах, төлөвлөлт хийнэ.** | | | **Батлуулсан баримт бичгийн тоо Судалгааны тоо** | **0**<br>**0** | **3**<br>**1** | **Батлуулсан ажлын даалгавар 2** | |
| 17 | Арга хэмжээ 5.1. Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулах. | - | Батлуулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | 1.Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2026)-ний хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийсэн талаарх тайланг ирүүлэх тухай 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 01/2266 дугаартай албан бичгийг Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд, 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01/2652 дугаартай албан бичгээр И-Монгол академи УТҮГ-т тус тус хүргүүлсэн.<br>2.Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам, И-Монгол академи УТҮГ-аас хэрэгжилтийн тайланг ирүүлсэн, ГБХНХЯ-наас тайланг ирүүлээгүй хүлээгдэж байна. Мөн Энэхүү төлөвлөгөө нь 2022-2026 онд хэрэгжиж байх тул 2026 онд шинэчлэн батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>3.Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төслөөр боловсруулсан. | 50 |
| 18 | Арга хэмжээ 5.2. Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангуулна. | - | Батлуулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:<br>1.Төрийн цахим шилжилтийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, төрийн албан хаагчдын цахим ур чадвар, бэлэн байдал, цахим шилжилтэд оролцогчдын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох судалгаа хийх, ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 47 дугаар тушаалаар баталсан.<br>2.Дээрх ажлын хэсгийн уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр холбогдох байгууллагуудтай | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран зохион байгуулж, дараах асуудлуудыг хэлэлцэж, санал солилцов:<br>- Цахим шилжилтийн бэлэн байдал: төрийн албан хаагчид болон иргэдийн цахим ур чадвар түвшинг тодорхойлох;<br>-Цахим шилжилтийн сэтгэл ханамж: Иргэдийн болон төрийн албан хаагчдын сэтгэл ханамж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдүүлэх боломж зэрэг асуудлыг ажлын даалгаварт тусгав.<br>2.Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулж, уг төсөлд Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөлөөс санал авч тусгасан. ЦХИХХ-ны сайд 2025 оны 12 дугаар сард тушаал баталсан. | |
| 19 | Арга хэмжээ 5.3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн бодлогын баримтлах чиглэл боловсруулж, батлуулна. | - | Батлуулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | 1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа их дээд сургуулиудын удирдлагуудтай хамтран ажиллах, санал солилцох уулзалтыг зохион байгуулахаар 23 их дээд сургуульд 2025 оны 03/127 дугаартай албан бичгээр хүргүүлж, уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Дээрх уулзалтаар их, дээд сургуулиудын багш нараас өгсөн саналыг бодлогын баримтлах чиглэлийн төсөлд тусган хэрэгжүүлж байна.<br>2. Монгол Улсыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр дараах зорилт, арга хэмжээг тусгасан:<br>-ЗГҮАХ-2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилт 4.3.2.6-д Дэлхийд өрсөлдөх чадвартай, технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай 1,000 мэргэжилтэн бэлтгэж, 1,000 өндөр технологийн ажлын байр бий болгох үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.",<br>4.3.3.6-д Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг чадавхжуулж, бүх нийтийн кибер аюулгүй байдлын мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ; | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 7.3.7.2-т Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлнэ.<br>-Засгийн газрын 2025 оны 108 дугаар тогтоолоор баталсан Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмжийн 2.1.5.5-д Технологийн дотоодын болон олон улсын тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэж, салбарт нарийн мэргэшлийн хүний нөөцийг нэмэгдүүлнэ. Дээрх бодлогын баримт бичгээс гадна Салбарын хүний нөөцийн мэдлэг ур чадварыг сайжруулах, тогтвортой чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, зорилгоор "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх баримтлах чиглэл"-ийн төслийг боловсруулаад байна. | |
| 20 | Арга хэмжээ 5.4. Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулна | - | Судалгааны тоо | 0 | 1 | 1."Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах" ажлын даалгаврыг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр батлав.<br>2."Төрийн үйлчилгээг цахимаар худалдан авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах" тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий "Үнэлгээний хороо байгуулах, зардал гаргах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/118 тушаал батласан бөгөөд төсөв татагдсан тул хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн. | 50 |
| **Зорилт 6. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг эрчимжүүлж, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгох ажлыг зохион байгуулах, зохицуулна.** | | - | Судалгааны тоо<br>Саналын тоо<br>Хэлэлцүүлгийн тоо | 0<br>0<br>0 | 3<br>1<br>1 | **Судалгааны тоо-4** | |
| 21 | Арга хэмжээ 6.1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр олон улсын байгууллагуудаас | - | Санал, зөвлөмжийн тоо | 0 | 1 | 1.Цахим засаглалын хөгжлийн индексийн (EGDI) 2026 оны судалгаа (6 бүлэг 62 асуулт, 87 дэд асуулт)-ны асуулгад санал боловсруулсан. Мөн Улаанбаатар хотын цахим шилжилтийн өнөөгийн байдлыг дээрх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргадаг индексийн харилцан уялдааг судалж, салбарын стратеги төлөвлөгөөнд тусгах санал, зөвлөмж боловсруулна. | | | | | судалгаанд тусгах зорилгоор "Хамтран ажиллах тухай" 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/1731 дугаар албан бичгийг Нийслэлийн Засаг даргад хүргүүлж, хамтран ажилласан. Нэгтгэсэн баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цахим засаглалын газарт цахим шуудан /monina.tran@un.org/-гаар 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн. Асуулга хариултад үндэслэн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал, зөвлөмж боловсруулсан.<br>2.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас ирүүлсэн 21 аймаг, нийслэл, сум, дүүргийн цахим шилжилтийн индексийг тодорхойлох үнэлгээний аргачлал, судалгааны асуулгатай танилцаж, холбогдох саналыг өгсөн. Мөн НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индексийн орон нутгийн индексийн асуумжийн дагуу шинээр асуулт боловсруулж, ажлын хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр танилцуулсан.<br>3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн олон улсын индексүүдийн 2024 оны үзүүлэлтийг судалж, холбогдох индексүүдийг ахиулах арга хэмжээний зорилтод түвшнийг тодорхойлон, ЦХИХХЯ-ны Стратеги төлөвлөгөө (2024-2028 он)-нд тусгасан. | |
| 22 | Арга хэмжээ 6.2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинээр боловсруулах болон шинэчлэх стандартад санал боловсруулж, хүргүүлнэ. | - | Саналын тоо | 0 | 1 | 2022-2025 оны Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын статистик мэдээллийг нэгтгэж, мэдээллийн сан бүрдүүлэх санал боловсруулсан. | 100 |
| 23 | Арга хэмжээ 6.3. Цахим эдийн засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулна. | - | Судалгааны тоо<br><br>Хэлэлцүүлгийн тоо | 0<br><br>0 | 1<br><br>1 | Монгол Улсын дижитал эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, бусад орны сайн жишгийн судалгаа хийх Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, олон улсын сайн туршлагыг судлах үндсэн дээр дижитал эдийн засгийн суурь судалгааг хийж, өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлж өргөжүүлэх, үр дүнтэй стратеги боловсруулах зорилгоор "Дижитал эдийн засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603059 дугаартай ажлын даалгаврыг | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлан 2025 оны А/136 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг зарласан боловч, төсөв татагдсан тул хэрэгжүүлэх боломжгүй болсон. | |
| 24 | Арга хэмжээ 6.4. Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулна. | - | Судалгааны тоо<br>Зөвлөмжийн тоо | 0<br>0 | 1<br>1 | "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө"-д туссан "Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулах ЦХИХХЯ/20250603060" дугаартай тендер-шалгаруулалтыг зохион байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 06/05 дугаартай албан бичгээр төслийн гүйцэтгэлийн эцсийн тайланг хүлээн авч, 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гэрээ дүгнэн акт үйлдэж, баталгаажуулсан. Төслийн хүрээнд "Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар зөвлөмж" боловсруулагдсан. | 100 |
| 25 | Арга хэмжээ 6.5. Төрийн байгууллагуудад ашиглаж буй мэдээллийн технологийн шийдэл, системүүдийн нэгдсэн судалгаа хийж, зөвлөмж боловсруулна. | - | Судалгааны тоо<br>Зөвлөмжийн тоо | 0<br>0 | 1<br>1 | И-Монгол академи УТҮГ-аас ашиглалт, үйлчилгээг нь хариуцдаг мэдээллийн системийн судалгаа (үндсэн болон дэд систем нийт 43)-г хийсэн ба Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/147 дугаар тушаалаар байгуулагдсан "Төрийн байгууллагын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, нэгдсэн удирдлага арга зүйгээр хангах" үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд хувийн хэвшилд шилжүүлэх боломжтой мэдээллийн систем, төр өөрөө ашиглалт үйлчилгээг нь хариуцан авч явах шаардлагатай мэдээллийн системийн жагсаалтыг гарган, тэдгээрийг зохицуулах эрх зүйн зохицуулалтын талаар санал боловсруулж, танилцуулах ажлыг эхлүүлээд байна. | 30 |
| **Зорилт 7. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх** | | - | **Хэрэгжилтийн хувь** | **0** | **100** | **61 акт** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | Арга хэмжээ 7.1. Захиргааны хэм хэмжээний актын салбарын нэгдсэн бүртгэл хөтлөх цахим системийг бий болгоно. | - | Системийн тоо | 0 | 1 | Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдийг мэдээллээр хангах ажлыг хариуцан ажиллаж байна. Салбарын санг цахим хэлбэрт шилжүүлэх талаар системийн ажлын даалгаврыг боловсруулж, И-Монгол академи УТҮГ-аар 2026 оны төлөвлөгөөнд тусгуулан хийлгэхээр төлөвлөөд байна. | 80 |
| 27 | Арга хэмжээ 7.2. Захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, журмаар зохицуулах харилцааг холбогдох хуульд тусгах асуудлаар салбарт хамаарах Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ. | - | Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн актын тоо | 0 | 26 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар нийт 15 хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах 78 эрх олгосон заалт туссанаас 61 акт батлагдсан. Эдгээр актуудад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулаад байна. Хуулийн төсөл батлагдсанаар 6 хуулийн хүрээнд эрх олгосон 7 журмын зохицуулалт хуульд тусаж, журам батлах эрх олгосон 9 заалт хүчингүй болох ба дээрх хуулийн төслийг "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д туссан хуулийн төслүүдтэй хамтатган боловсруулахаар төлөвлөөд байна. | 100 |
| **Зорилт 8. Олон улсын, бүсийн, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлнэ.** | | - | **Хэрэгжилтийн хувь** | **0** | **100** | **100** | |
| 28 | Арга хэмжээ 8.1. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулна. | - | Батлагдсан баримт бичиг | 1 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сард баталсан. Уг төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг гарган тайлагнасан. | 100 |
| 29 | Арга хэмжээ 8.2. Олон улсын байгууллага, гадаад улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулах, Гадаад | - | Бүртгүүлсэн гэрээ хэлэлцээрийн тоо | 0 | 4 | Тайлант хугацаанд 5 Харилцан ойлголцлын санамж бичиг, 1 Хамтран ажиллах санамж бичиг, 2 гэрээг айлын талтай эцэслэн тохирч, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ. | | | | | 1.Монгол Улсын “И-Монгол академи” УТҮГ болон Бүгд Найрамдах Киргиз Улсын “Тундук” Улсын үйлдвэрийн газар хооронд цахим засаглалын чиглэлээр хамтран ажиллах Харилцан ойлголцлын Санамж бичиг;<br>2.Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Польш Улсын Цахим хэргийн яам хооронд цахим шилжилт, хиймэл оюуны чиглэлээр хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг;<br>3.Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Тажикистан Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Инновац, дижитал технологийн агентлаг хооронд цахим шилжилтийн салбарт хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг;<br>4.Монгол Улсын "И-Монгол академи" УТҮГ болон Бүгд Найрамдах Тажикистан Улсын «Гэрчилгээний төв, төрийн үйлчилгээ, дижитал хөтөлбөр хөгжүүлэлт» ХК хооронд хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг;<br>5.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага хооронд “Ази, Номхон далайн бүсийн кибер сургуулилт-2025”-ыг Монгол Улсад 2025 оны 09 дүгээр сарын 02-05-ны өдрүүдэд зохион байгуулах тухай Тохиролцооны захидал /Letter of Agreement/;<br>6.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр хооронд байгуулах “Санхүүжилтийн гэрээ”;<br>7.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон ОРАКЛ компани хооронд Oracle Academy хөтөлбөрөөр дамжуулан Монгол Улсын 60,000 эмч, багш зэрэг төрийн албан хаагчид болон иргэдэд олон улсын түвшний сургалтын хөтөлбөр, дижитал платформуудыг үнэ төлбөргүй ашиглуулах боломжийг бүрдүүлэх зорилготой Хамтран ажиллах санамж бичиг;<br>8.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Электроникс, мэдээллийн технологийн яам хооронд цахим шийдлийн талаар туршлага солилцох чиглэлээр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус хянуулж, баталгаажуулсан. | |
| 30 | Арга хэмжээ 8.3. Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон яамны хэмжээнд албан болон ажлын айлчлал, гадаад томилолтыг зохион байгуулна. | - | Оролцсон арга хэмжээний тоо | 0 | 48 | 1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улсад 2025 оны 01 дүгээр сарын 26-наас 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд ажлын айлчлал хийхээр төлөвлөж, ГХЯ болон холбогдох Элчин сайдын яамдтай хамтран уг айлчлалын бэлтгэл ажлыг хангаж, зардлын асуудлыг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/189 дугаартай тушаалаар албажуулсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан.<br>2.Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од Дэлхийн Банкны хэрэгжүүлж буй "Ухаалаг засаг-2" төслийн хүрээнд цахим шилжилт, шинэ өндөр технологи судлах, туршлага солилцох хөтөлбөрт оролцохоор Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025 оны 2 дугаар сарын 9-16-ны өдрүүдэд албан томилолтоор ажилласан.<br>3.Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од АНДСХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох тус байгууллагын Онцгой Удирдах зөвлөлийн хуралд 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо оролцохоор төлөвлөж, ГХЯ-наас холбогдох санал, бүрэн эрхийг авсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж оролцоогүй.<br>4.ЦХИХХ-ны сайд Ц.Баатархүү Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны байгууллагаас Токио хотноо 2025 оны 5 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулсан "Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл, харилцаа холбооны сайд нарын уулзалт"-д оролцож, Япон Улсад ажлын айлчлал хийхээр төлөвлөн, холбогдох бэлтгэл ажлыг ГХЯ болон Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан. Мөн сайдын гадаад томилолтын асуудлыг 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, удирдамжийг батлуулсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжлэх ухаан, технологийн яамнаас тус улсын "Бүс ба зам" санаачилгын хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 08-наас 12-ны өдрүүдэд Сычуань мужийн Ченду хотноо зохион байгуулах "Шинжлэх ухаан, технологийн хоёрдугаар бага хурал"-д оролцож, тус улсын дэлхийн хамгийн том дата төв болох Хөх хот дахь Өвөрмонголын мэдээллийн парк (China Telecom–Inner Mongolia Information Park)-ийн үйл ажиллагаатай танилцах уулзалтыг хийхээр төлөвлөн холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан болно.<br>6.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Тажикистан Улсад хийсэн төрийн айлчлалын бүрэлдэхүүнд ажиллаж, ЦХИХХЯ болон БНКиУ-ын Цахим хөгжил, шинэ технологийн яамтай цахим шилжилтийн салбарт хамтрах ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг, Бүгд Найрамдах Тажикистан Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Инновац, дижитал технологийн агентлаг хооронд цахим шилжилтийн салбарт хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус байгуулав.<br>7.Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Золбаяр Ази, Номхон Далайн Сансрын Хамтын Ажиллагааны Байгууллагын Удирдах зөвлөлийн хуралд 2025 оны 12 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд тус байгууллагын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хэлэлцэж, санал өгч оролцов. | |
| 31 | Арга хэмжээ 8.4. Гадаад улс орнуудад зохион байгуулах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үзэсгэлэн, экспод төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Тайлант хугацаанд гадаад улс орнуудад зохион байгуулсан мэдээлэл, харилцаа холбооны салбарын 1 арга хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцоход дэмжлэг үзүүлсэн.<br>Испанийн Хаант Улсын Барселон хотноо 2025 оны 03 дугаар сарын 03-05-ны өдөр зохион байгуулагдсан "Дэлхийн үүрэн холбооны конгресс 2025" -д оролцсон хувийн хэвшлийн CallPro, Online Net-work болон DDish | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцуулах ажлыг зохион байгуулна. | | | | | компаниас оролцсон 9 төлөөлөгчдөд ГХЯ-наас ХБНГУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-нд ноот бичиг гаргуулж, визний асуудалд дэмжлэг үзүүлсэн. | |
| 32 | Арга хэмжээ 8.5. Олон улсын, бүсийн, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажил зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Бүгд Найрамдах Социалист Вьетнам, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Хятад, Америкийн Нэгдсэн улс, Япон, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Европын холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайдуудтай болон БНСУ-ЫН Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага КОЙКА-гийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч, Дэлхийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгч, Азийн хөгжлийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч, Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагч, Дэлхийн Шуудангийн Холбооны дэд захирал, Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Ази, Номхон далайн бүсийн захиралтай Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд олон улсын, бүсийн, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажил зохион байгуулах хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд 21 удаагийн уулзалт зохион байгуулж, санал солилцсон. Түүнчлэн Бүгд Найрамдах Франц Улсын Сансрын агентлаг болон Талес компанийн төлөөлөл, БНСУ-ЫН Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага КОЙКА-гийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны Хөрөнгө оруулалт хариуцсан захиралтай Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон салбарыг төлөөлөн уулзалт зохион байгуулав. | 100 |
| **Яамны стратегийн зорилт 2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийг төрөөс иргэдэд үзүүлдэг үйлчилгээг дахин инженерчлэл хийх, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй хүргэхэд чиглүүлэн хөгжүүлэх** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бизнес процессын дахин инженерчлэл хийх | | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | 76 | |
| 33 | Арга хэмжээ 1.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулна. | - | Судалгааны тоо-1 Зөвлөмжийн тоо-1 | 0 | 2 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем болон мэдээллийн сүлжээ, нийтийн мэдээллийн сангийн хэрэглээ, түүний ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн зураглалыг гаргаж, нэгдсэн зөвлөмж, заавар боловсруулах зорилготой тендерийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг тус тус боловсруулж, уг тендерийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан боловч, оролцогч орж ирээгүй. Иймд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/319 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, журмын төслийг боловсруулж байна. | 30 |
| 34 | Арга хэмжээ 1.2. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг бий болгоно. | - | Аргачлалын тоо | 0 | 1 | "Мэдээлэл хариуцагчийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх журам"-ыг боловсруулан, батлуулахаар "Үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, журам, танилцуулгад санал авах 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2562 тоот бичгийг Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн. Саналыг нэгтгэж, ЗГХЭГ-т тогтоолын төслийг хүргүүлсэн. | 90 |
| 35 | Арга хэмжээ 1.3. Төрийн байгууллагын үйлчилгээнд процессын дахин инженерчлэл, шинжилгээ хийнэ. | - | Байгууллагын тоо | 0 | 2 | Тус яамнаас Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Ухаалаг засаг 2 төсөл"-ийн 2026 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.1.11.2-д "Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл хийх" төслийн ажлын даалгаврыг боловсруулсан. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | загварчлах, үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий А/102 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс гарсан үр дүнг танилцуулах шатанд ажиллаж байна. Түүнчлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа Засгийн газрын агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас "Систем арт венчурс" ХХК, "Ай эм эс" ХХК-тай хамтран Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийж тайланг хүлээлгэн өгсөн. | |
| 36 | Арга хэмжээ 1.4. Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ийг тархсан бүтцэд шилжүүлнэ. | - | Тархмал бүтцэд шилжсэн мэдээлэл хариуцагч байгууллагын тоо | 0 | 3 | "Ухаалаг засаг 2 төсөл" -ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.2.2.2-т заасан "Бие даасан техникийн зөвлөх/ХУР систем"-ийн зөвлөх сонгон шалгаруулж, ажил, үйлчилгээг 2025.04.30-2027.04.30-ны өдрийн хооронд хэрэгжүүлэхээр 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн SG-II/CS/2.2.2.2 дугаартай гэрээ байгуулагдсан.<br>- "Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх" зөвлөх үйлчилгээний ажлын явц болон гүйцэтгэгчийн тайланг хянан баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/188 дугаар тушаалаар байгуулсан.<br>- Зөвлөхийн ирүүлсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн явц болон тайланг ажлын хэсэгт хүргүүлэх, хянан үзэх, санал боловсруулан хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>- Ажлын даалгавар, төлөвлөгөөний дагуу ХУР системийн техникийн болон функциональ даалгавар, тархмал архитектур шийдэл, систем хөгжүүлэх, шаардлагатай техник хангамжийн нөөц, техникийн үзүүлэлтүүд, төсөв зардлын тооцоо, систем хөгжүүлэх хуваарийг тус тус гаргасан.<br>- Судалгааны үр дүнд мэдээлэл хариуцагч 3 байгууллагад ХУР системийг тархаан байршуулахаар тархмал бүтэцтэй системийг хөгжүүлэх, дэд бүтцийн тоног төхөөрөмжийн ажлын даалгаврыг боловсруулж, төслийн нэгжид хүргүүлсэн. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | Арга хэмжээ 1.5. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт боловсруулна. | | Хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн тоо | 0 | 12 | Зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий 2022 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг isr.gov.mn цахим системээр авч байна. 2025 онд нийт 18 зөвлөмжийг хүргүүлсэн. Жишээлбэл: Албан бичгээр Гадаадын иргэн, харьяатын газарт 2025.01.03-ны өдөр, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2025.02.18-ны өдөр, Зам тээврийн яаманд 2025.02.26-ны өдөр, "system.gov.mn" системээр Ашигт малтмал газрын тосны газарт 2025.02.04-ний өдөр, Үндэсний статистикийн хороонд 2025.02.28-ны өдөр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2025.05.16-ны өдөр, Төрийн орон сууцны корпорац ХХК-д 2025.05.17-ны өдөр, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 2025.05.17-ны өдөр, Цагдаагийн ерөнхий газарт 2025.09.10-ны өдөр, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025.09.11-ний өдөр, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025.09.11-ний өдөр мөн цахим шуудангаар буюу бусад хэлбэрээр Гадаадын иргэн, харьяатын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Улсын ерөнхий прокурорын газарт 2025.12.04-ны өдөр, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд, Хууль зүйн туслалцааны төвд 2025.02.17-ны өдөр тус тус зөвлөмж гарган хүргүүлсэн болно. | 100 |
| 38 | Арга хэмжээ 1.6. "Тусгай дугаар 112"-ын үйл ажиллагаанд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийг судалгаа хийнэ. | - | Судалгааны тоо | 0 | 1 | Ажлын даалгаврыг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 39 | Арга хэмжээ 1.7. Камерын хяналтын нэгдсэн систем бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмжийн нөхцөл шаардлагыг тодорхойлох | - | Судалгааны тоо | 0 | 1 | Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн "Танилцуулга хүргүүлэх тухай" 7/2857 дугаар албан бичгээр "улсын хэмжээнд нэгдсэн дугаарлалтын систем нэвтрүүлэх, нийслэлд Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг өргөтгөх, | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | суурь судалгаа хийж стандартын төсөл боловсруулах. | | | | | орон нутагт дуудлага хүлээн авах ажиллагааг Телекамерын хяналтын дэд төвтэй уялдуулан зохион байгуулах" ажлын Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулахад шаардлагатай системийн шинжилгээ хийлгэх танилцуулга ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан холбогдох албан хаагчидтай мэдээлэл солилцох зорилго бүхий уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. | |
| 40 | Арга хэмжээ 1.8. Шил ажиллагааны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчилна. | 18.0 Урсгал зардал | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Шил ажиллагааны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчилах хүрээнд Ажлын даалгаврыг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан.<br>Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон.<br>-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны "Штаб шинэчлэн байгуулах тухай" А/46 дугаар тушаалын дагуу Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран мэдээлэл хариуцагч байгууллага хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг ил тод байршуулсан эсэхэд Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан үнэлгээ өгөн, холбогдох заавар, мэдээллээр хангаж ажиллаж, нийт 3,980 байгууллагын 4,065 албан хаагчдад системийн хандах эрхийг олгож, 2,794 албан хаагчдыг сургалтад хамруулсан. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас нээлттэй мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор Монголын Үндэсний Олон нийтийн телевиз, "Ийгл" телевизүүдээр мэдээллийг хүргэн ажилласан. | 100 |
| 41 | Арга хэмжээ 1.9. Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулна. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | -"Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" судалгааны ажлын даалгаврыг боловсруулсан.<br>-Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж дуусаагүй шалтгаанаар санхүүжилт нь төсвийн-хэмнэлтэд-тооцогдсон. | |
| 42 | Арга хэмжээ 1.10. Цахим засаглалыг эрчимжүүлж, салбар бүрийн эрх зүйн орчны реформ хийнэ. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тушаалын хүрээнд "Цахим засаглалыг эрчимжүүлэх, салбар бүрийн эрх зүйн орчны реформ хийхэд хуулийн зөвлөх үйлчилгээ"-ний ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан. Улмаар 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Тус тендерийг 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр нээж, "Өмгөөллийн Баяр энд Ока партнерс" ХХК-аас 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн гомдол гаргасан бөгөөд хариуг 05 дугаар сарын 23-ны өдрийн Үнэлгээний хорооны хурлын шийдвэр, мэдэгдлийн хамт хүргүүлсэн.<br><br>Тус тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй бөгөөд Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тус төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 50 |
| 43 | Арга хэмжээ 1.11. Цахим шилжилтийг салбар бүрд эрчимжүүлэхэд тухайн салбарын талаарх хөндлөнгийн анализ бүхий материал, нэвтрүүлэг, контент хийнэ. | - | Контентын тоо | 0 | 1 | Ажлын даалгаврыг боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан. Үйлчилгээ авах тендерийг зохион байгуулах 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/124 дугаартай үнэлгээний хорооны тушаал батлан 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр тендер нээж, үнэлгээ хийсэн. Зөвлөмжийг удирдлагад танилцуулсан. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 2. Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах | | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Зөвлөмж хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо-0<br>Нэвтрүүлсэн системийн тоо-0<br>Зөвлөмжийн тоо-0 | |
| 44 | Арга хэмжээ 2.1. "Дижитал-Аймаг, Дижитал-Хот" зөвлөмжийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана. | - | Зөвлөмж хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо | 2 | 8 | "Цахим аймаг–Дижитал хот" зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хэсгийн тушаалыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулсан. "Дижитал-Аймаг, Дижитал-Хот" зөвлөмжийг боловсруулж, хэрэгжүүлэх" худалдан авах ажиллагааг 2025 оны 05 дугаар сард зарласан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 45 | Арга хэмжээ 2.2. Төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбарыг бүртгэх, хадгалах систем нэвтрүүлнэ. (GITLAB) | 600 урсгал зардал | Нэвтрүүлсэн системийн тоо | 0 | 1 | Үндэсний дата төв УТҮГ-ын дотоод нөөцөд тулгуурлан төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбарыг бүртгэх, хадгалах "git.ndc.gov.mn" системийг 2025 оны 09 дүгээр сард ашиглалтад нэвтрүүлж, танилт, нэвтрэлтийн систем (Dan2.0-23 service, dan 2.0 mobile), "geree.gov.mn", "billing.datacenter.gov.mn", "e-meeting", "epass" системүүдийн эх кодыг байршуулсан. Түүнчлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тушаалын хүрээнд "Төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбар бүртгэх, хадгалах систем нэвтрүүлэх" үйлчилгээний ажлын даалгаврыг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 03/327 тоот бичгийн дагуу Үндэсний дата төв УТҮГ-тэй хамтран боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улмаар үнэлгээний хороог 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар байгуулан 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр ЦХИХХЯ/20250103050 дугаартай худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Тендерт шалгарсан оролцогчдод гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлж, гэрээ зардлын тушаалыг батлуулсан боловч Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тус төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. Уг тендерийг цуцалсан тухай 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 02/1728 тоот албан бичгийг шалгарсан "Эй Ти Си Жи" ХХК-д хүргүүлсэн. | |
| 46 | Арга хэмжээ 2.3. Шүүхийн салбарын цахим шилжилт төслийг хэрэгжүүлэх суурь судалгаа хийж зөвлөмж боловсруулна. | 20 урсгал зардал | Зөвлөмжийн тоо | 0 | 1 | Шүүхийн салбарын цахим шилжилт төслийг хэрэгжүүлэх суурь судалгаа хийх ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаарсарын 31-ний өдөр баталсан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| **Зорилт 3. Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөлт хийх, мэргэжил, арга зүй, технологийн шийдэл, удирдлагаар хангах** | | **-** | **Хэрэгжилтийн хувь** | **0** | **100** | **Хөгжүүлж, нэвтрүүлсэн хувилбар-1**<br>**Системийн тоо-0**<br>**Блокчэйн технологи нэвтрүүлсэн бүртгэлийн үйлчилгээний тоо-0**<br>**Хүргүүлсэн баримт бичиг-1**<br>**Нэвтрүүлсэн программ-0**<br>**Нэвтрүүлсэн систем-0** | |
| 47 | Арга хэмжээ 3.1. Төрийн үйлчилгээг хиймэл оюуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий "Ухаалаг E-Mongolia" системийг хөгжүүлнэ. | - | Хөгжүүлж, нэвтрүүлсэн хувилбар | E-Mongolia 4.0 | E-Mongoli a 5.0 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ийн 5.0 хувилбарын хөгжүүлэлтийн хүрээнд Хиймэл оюунд суурилсан ухаалаг автомат хариулагчтай харилцах, Төрийн үйлчилгээний хөтөчөөр дамжуулан үйлчилгээгээ хялбар олох, хэтэвчээр дамжуулан төрийн үйлчилгээний төлбөр тооцоог төлөх, хэрэглэгч өөрийн тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэлэлтэй танилцах, судалгаанд оролцох, төрийн байгууллагаас хэлэлцүүлж буй хэлэлцүүлэгт санал өгөх зэрэг боломжуудыг бүрдүүлсэн. Мөн төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудастай холбож төрийн байгууллагаас ил тод нээлттэй байршуулахаар туссан 68 төрлийн мэдээллийг нэг дороос авах, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд системийг ашиглах зөвлөгөөгөөр хангаж, хамгийн сүүлийн үеийн загвар дизайн бүхий системийг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр 1268 төрийн үйлчилгээг үзүүлж байна. | |
| 48 | Арга хэмжээ 3.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай системүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг зохион байгуулах. | - | Системийн тоо | 0 | 2 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай системүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар судалж байна. | 0 |
| 49 | Арга хэмжээ 3.3. Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулна. | - | Блокчейн технологи нэвтрүүлсэн бүртгэлийн үйлчилгээний тоо | 0 | 1 | Ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/96 тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. "Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах" үйлчилгээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлан 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр нээсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулах санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | Арга хэмжээ 3.4. Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программын нэгж лицензийн үнийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | Шадар сайдын Ажлын алба, ТЕГ-ын Мэдээллийн аюулгүй газар, ЗГХХГ, ТХААГ, ҮДТ, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/124 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02/1997 тоот бичгээр ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлэн, явцын тайланг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр, үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/2684 тоот бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралд танилцуулсан. Ажлын хэсгийн хүрээнд ЦХИХХЯ болон Майкрософт корпорацтай харилцан ойлголцлын санамж бичиг болон нууцлалын гэрээ байгуулах шийдвэрийг гаргаж, 2025 оны 12 дугаар сарын байдлаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг болон нууцлалын гэрээг байгуулсан. Ингэснээр дэвшилтэт технологи ба инновацаар дамжуулан төрийн дижитал шилжилтийг хурдасгаж, цахим эдийн засаг, цахим боловсролыг дэмжиж, оюуны өмчийн эрхийг хамгаалалтыг сайжруулан, өгөгдөл, мэдээллийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хадгалах дэд бүтэц ба кибер аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх хүрээнд нийт 12 зорилтыг хэрэгжүүлэх боломж бүрдсэн болно. | 100 |
| 51 | Арга хэмжээ 3.5. Кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах программ нэвтрүүлнэ. | - | Нэвтрүүлсэн программын тоо | 0 | 1 | Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан Дуаллайн ХХК-ийн эзэмшлийн, "Алдаа шалгагч, бичиг хөрвүүлэгч" буюу кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлж, зөв бичгийн дүрмийн алдаа хянах системийг төрийн бүх шатны байгууллагын хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тус ажлын хүрээнд яамнаас Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ гаргуулахаар Тагнуулын ерөнхий газар руу 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 03/467, 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 02/1957 дугаар "Дүгнэлт, зөвлөмж гаргуулах тухай" албан бичгүүдийг хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тагнуулын ерөнхий газраас дээрх системийн кибер аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, эмзэг байдлыг шалган турших боломжгүй бөгөөд төрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглахад аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй талаар мэдээлэл ирүүлсэн. Монгол хэлний тухай хуульд заасан дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхэд Кибер аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-д заасан аюулгүй байдлын шаардлагыг хангасан системийг цахим орчинд нэвтрүүлэх боломжтой талаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албанд 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/2537 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Мөн 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03/2731 дугаар албан бичгээр Дуаллайн ХХК-д системийг төрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж, хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлсэн. | |
| 52 | Арга хэмжээ 3.6. Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгоно. | - | Системийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тушаалын хүрээнд "Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгох" үйлчилгээний ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан. 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар байгуулсан үнэлгээний хороо ажиллаж, 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЦХИХХЯ/20250103041 дугаартай худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан боловч Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тус төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. Иймд тендер цуцалсан тухай 2025 оны 07 дугаар сарын 28-ны | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн 02/1728 тоот бичгийг шалгарсан "Ай Си Ти трейнинг" ХХК-д хүргүүлсэн.<br><br>2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/311 дүгээр тушаалын хүрээнд "Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэдээллийн технологийн мэргэжилтний бүртгэлийн систем хөгжүүлэх" үндэслэл, ажлын даалгаврыг дахин 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталж, шууд худалдан авалтыг зохион байгуулан, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Ү/28 дугаартай гэрээ байгуулж, системийн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн. | - |
| **Зорилт 4. Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах** | | **-** | **Хэрэгжилтийн хувь** | **0** | **100** | **Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо-0<br>Их өгөгдлийн сан үүсгэх гүйцэтгэлийн хувиар-90<br>Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо-55** | |
| 53 | Арга хэмжээ 4.1. Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэл хөтөлнө. | - | Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо | 0 | 45 | Засгийн газрын 2024 оны 77 дугаар тогтоолоор баталсан "Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах" журамд нийцүүлэн "Төрөлжсөн бүртгэлийн сангийн нэгдсэн систем хөгжүүлэх" ажлын даалгавар баталсан. Үүний дагуу "Төрийн мета-өгөгдлийн платформ"-д нэмэлт хөгжүүлэлт хийж, "Төрөлжсөн мэдээллийн сангийн нэгдсэн систем"-ийг хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон.<br><br>"Төрөлжсөн мэдээллийн сангийн нэгдсэн систем"-д мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сан - 68, статистикийн – 48, хүснэгт - 718, үзүүлэлт – 10528, ангилал, код - 1686 бүртгэгдсэн болно. | 80 |
| 54 | Арга хэмжээ 4.2. Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэнэ. | - | Их өгөгдлийн (big data) сан үүсгэх гүйцэтгэлийн хувиар | 0 | 10 | Хүний хувийн мэдээлэлд хамаарах 35, хуулийн этгээдэд хамаарах 14 төрлийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгсэл, өгөгдлийг ХУР системээр нууцлалтай дамжуулах сервисийг И-Монгол академи УТҮГ-тай хамтран хөгжүүлсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Мэдээллийн сангуудын өгөгдлийг нэгтгэхэд шаардлагатай нөөц (CPU 16 Core, RAM - 24GB, HDD-40GB)-ийг Үндэсний дата төв дээр үүсгэсэн.<br>Мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг ХУР системээр дамжуулах сервисийг ашиглан Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн мэдээллийн сан, Хүн амын өрхийн мэдээллийн сан, Мал тооллогын мэдээллийн сан, Бизнес регистрийн мэдээллийн сангийн мэдээлэл (өрхийн мэдээлэл 1,000,313 мөр өгөгдөл, иргэний - 3,531,278 мөр өгөгдөл, даатгуулагч иргэний - 18,142,864 мөр өгөгдөл, халамжийн - 1,000,000 мөр өгөгдөл) бүхий 5 мэдээллийн санг Үндэсний дата төв УТҮГ-т байрлах өгөгдлийн санд туршилтаар байршуулсан.<br>Их өгөгдлийн санд нэгтгэсэн өгөгдлийг урьдчилан боловсруулах, нэгтгэх, дүрслэн харуулах үе шатны ажлыг эхлүүлэх зорилгоор Үндэсний статистикийн хорооны холбогдох албан хаагчид их өгөгдлийн санд хандах эрх, боловсруулалт хийх виртуал орчинг үүсгэж, ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>-Их өгөгдлийн сан бүрдүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн санхүүжилтийг "Ухаалаг засаг – 2" төсөлд тусгаж, шийдвэрлүүлэхээр "Төрийн их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн бэлэн байдлыг хангах" төслийн саналыг боловсруулж, Ухаалаг засаг – 2 төслийн нэгжид хүргүүлсэн.<br>-2026 оны улсын төсөвт 16,7 тэрбум төгрөг Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюун, их өгөгдлийн суурь дэд бүтцийн тоног төхөөрөмж нэртэйгээр батлагдсан. Суурь судалгаа хийгдсэн. 2026 онд хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан. | |
| 55 | Арга хэмжээ 4.3. Хүн, хуулийн этгээдийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д холбох ажлыг зохион байгуулна. | - | Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо | 0 | 55 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд төрийн 189, хувийн хэвшлийн 512 байгууллага, нийт 701 байгууллага холбогдсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | Арга хэмжээ 4.4. Хүн, хуулийн этгээдийг танилт, нэвтрэлтийн систем (Дан)-д холбох ажлыг зохион байгуулна. | - | Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо | 0 | 50 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 108 байгууллагын 216, хувийн 314 байгууллагын 374 систем бүртгэлтэй 2,284,806 иргэн байна. | 100 |
| 57 | Арга хэмжээ 4.5. Сэлгэн ажиллах /high availability/ дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгоно | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Үндэсний дата төв УТҮГ-аас Сэлгэн ажиллах нөөц төвд шаардлагатай сервер, сүлжээ, хадгалах төхөөрөмж зэрэг 10 төрлийн нийт 128 ширхэг техник хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан ирүүлсний дагуу "Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх" ЦХИХХЯ/20250102135 дугаар бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.<br>Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж дуусаагүй шалтгаанаар санхүүжилт нь төсвийн хэмнэлтэд тооцогдсон. | 30 |
| 58 | Арга хэмжээ 4.6. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв /11-11/ болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, мэдээллийн системийг нэгтгэх асуудлыг судалж, Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025 оны 175 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан, ЗГХЭГ, ЗГХХГ, "И Монгол академи" УТҮГ болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, явцын тайланг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр, үр дүнг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/2711 тоот бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралд танилцуулсан. Ажлын хэсгийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23.1.2 дахь заалтыг үндэслэн Иргэд, олон нийттэй харилцах /11-11/ төвийн мэдээллийн системийг "Мэдэгдэл хүргэх систем"-тэй холбож, улмаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн явц, шийдвэрийн талаар мэдэгдэл хүргэдэг болсон;<br>-Засгийн газрын "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-д Иргэд, олон нийттэй харилцах /11-11/ төвд ирсэн дуудлага, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түүний төрөл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл болон нийслэлийн хэмжээнд 101, 102, 103, 105 дуудлагын утасны мэдээллийг дашбоард хэлбэрээр харах боломжийг бүрдүүлсэн;<br>-Иргэдийн гадаад улсаас хийх дуудлагыг хүлээн авахад "(+976) 7039-1111" дугаарлалт ашиглах боломжтой талаарх саналыг 01/613 тоот бичгээр хүргүүлсэн. Улсын хэмжээнд төрийн 34 байгууллагын 38 тусгай дугаарыг ашиглан иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч, зөвлөгөө мэдээлэл өгч байгаа судалгааг гаргасан;<br>-Иргэдийн асуултад хариулах, хууль эрх зүйн зөвлөмж өгөх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг мэдээлэх чадвартай хиймэл оюунд суурилсан "IVA" системийг "11-11.mn" веб хуудаст холбож, "Харилцагчийн үйлчилгээний хиймэл оюуны виртуал ажилтан, операторын үйлчилгээ"-г 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн туршсан;<br>- Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв /11-11/ болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, мэдээллийн системийг нэгтгэх "Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн сан"-г хөгжүүлэн, Үндэсний дата төвд дэд бүтцийг шийдвэрлэн "MCloud" серверт байршуулж, 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн ашиглалтад оруулсан;<br>-Санд төрийн бүх байгууллагын өргөдөл, гомдлыг нэгтгэх зорилгоор төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системээр дамжуулан мэдээлэл солилцох 5 төрлийн API сервисийг хөгжүүлэн, гарын авлагыг нээлттэй байршуулсан;<br>-Санд "EMongolia" ERP, "Able" ERP; НЗДТГ-ын ERP системүүдийг холбосон;<br>-Мэдээллийн сан ашиглалтад орсноос хойш давхардаагүй тоогоор 4,497 иргэнээс төрийн 180 байгууллагад хандсан 5,460 өргөдөл, гомдол, хүсэлт, саналыг бодит цаг хугацаанд бүртгэсэн байна. | |
| 59 | Арга хэмжээ 4.7. Үндэсний программ хангамжийн их | - | Нэвтрүүлсэн системийн тоо | 0 | 1 | Үндэсний программ хангамжийн их дэлгүүр систем нэвтрүүлэх ажил төсөв, санхүүжилтээс шалтгаалан хүлээгдэж байна. | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэлгүүр систем (Mindgolia) 2.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | | | | | | |
| 60 | Арга хэмжээ 4.8. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-ийн 3.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | - | Нэвтрүүлсэн системийн тоо | 0 | 1 | Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-ийн 3.0 хувилбарыг хөгжүүлэх ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/88 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулсан. 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр тендер нээж, үнэлгээ хийсэн.<br>Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 61 | Арга хэмжээ 4.9. “Ухаалаг засаг II” төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Гадаадын зээл | Төсөл, хөтөлбөрийн тоо | 10 | 20 | “Ухаалаг засаг 2” төсөл нь 2024-2027 оны хооронд хэрэгжиж буй Дэлхийн банкнаас зээлийн санхүүжилттай төсөл юм. Төслийн удирдах хорооноос 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан ба төлөвлөгөөний дагуу дараах ажлуудын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:<br>✓ Төлөвлөгөөнд туссан 27 төслийн гэрээ баталгаажуулсан. Үүнээс 11 төсөл бүрэн хэрэгжиж дууссан, 18 төслийн гэрээ хэрэгжин ажиллаж байна.<br>✓ Төлөвлөгөөнд туссан 2 төслийн гэрээний төслийг боловсруулан ажиллаж байна.<br>✓ Төлөвлөгөөнд туссан 1 төсөл Олон Улсад болон олон нийтэд 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зарлагдсан. 2025.12.10-ны өдөр тендерийн нээв.<br>✓ Төлөвлөгөөнд туссан 5 төслийн ажлын даалгавар Дэлхийн банк болон яамнаас батлагдсан ба төслийн ТББ боловсруулан ажиллаж байна.<br>✓ Төлөвлөгөөнд туссан 5 төслийн ажлын даалгавруудыг Дэлхийн банк болон Төсөл хэрэгжүүлэх нэгж, Төслийн үр шим хүртэгч байгууллагуудтай хамтран боловсруулан ажиллаж байна. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ухаалаг засаг 2 төслийн зарцуулалт өссөн дүнгээр 3,200,000$ байна. | |
| 62 | Арга хэмжээ 4.10. Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | - | Нэвтрүүлсэн хувилбар | 2.0 | 3.0 | Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг хөгжүүлэх ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/88 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан. 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр тендерийг нээж, үнэлгээ хийсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон.<br>-Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын хүрээнд төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-тэй уялдуулах талаарх 2025.02.28-ны өдрийн 01/502 тоот бичгийг И-Монгол академи УТҮГ-т хүргүүлж, улмаар И Монгол академи УТҮГ, систем хөгжүүлэгч "Аствишн" ХХК-тай холбогдох уулзалтуудад /2025.03.18, 03.25, 04.24, 05.29, 06.05/ оролцож, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.<br>-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системд 4,572 байгууллагын 5,113 албан хаагчид хандах эрхийг олгож, Шилэн индексийн тайланг боловсруулж, 2025.10.03-ны өдрийн 01/2274 тоот бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд мэдээлэл хариуцагч байгууллагаас нээлттэй өгөгдөл, мэдээллийг байршуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангуулах зорилгоор "Нээлттэй мэдээллийн систем" /shilen.gov.mn/-ийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт шилжүүлэн хариуцуулах 2025.09.17-ны өдрийн А/126 тоот тушаалыг боловсруулан батлуулж, 02/2162 тоот албан бичгээр ТЦҮЗГ, ҮДТ-д хүргүүлсэн. /Тус системийг блансаас блансад шилжүүлэх ТӨБЗГ-ын 2025.12.01- | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ний өдрийн А-1/2311 тоот бичгээр ирүүлсэн зөвшөөрөлтэй./ | |
| 63 | Арга хэмжээ 4.11. Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлнэ. | 350.0 Урсгал зардал | Нэвтрүүлсэн хувилбар | 1.0 | 2.0 | - "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем хөгжүүлэх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан.<br>- Дүгнэлт, зөвлөмжийн системийг суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэлтэй нэгтгэн "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлэх" ажлын даалгаврыг боловсруулсан.<br>- "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлэх" ЦХИХХЯ/20250103043 дугаартай тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.<br>- Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж дуусаагүй шалтгаанаар санхүүжилт нь төсвийн хэмнэлтэд тооцогдсон.<br>- "Төрийн мета-өгөгдлийн платформ"-д нэмэлт хөгжүүлэлт хийж, "Төрөлжсөн мэдээллийн сангийн нэгдсэн систем"-ийг хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон. | 80 |
| 64 | Арга хэмжээ 4.12. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслөөр ногоон дата төв байгуулах төслийн санал боловсруулна. | - | Төслийн саналын тоо | 0 | 1 | Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрших Хүннү хотод ногоон дата төв байгуулахаар ажлын даалгаврыг боловсруулан саналыг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | 90 |
| 65 | Арга хэмжээ 4.13. Олон нийтийн байгууллагуудын засаглалыг дэмжих нээлттэй платформ хөгжүүлнэ. | - | Платформын тоо | 0 | 1 | Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/93 тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. Үйлчилгээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлан 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр нээсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | |
| 66 | Арга хэмжээ 4.14. Авто ослын баримтжуулалтын систем (ослын баримт баталгаажуулалтын платформ) хөгжүүлнэ. | - | Платформын тоо | 0 | 1 | Авто ослын баримтжуулалтын систем (ослын баримт баталгаажуулалтын платформ) хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталж, үйлчилгээ авах тендерийг зохион байгуулах 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/95 дугаартай үнэлгээний хорооны тушаал баталсан. 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр тендерийг зарлаж, 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр тендер нээж үнэлгээ хийсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 67 | Арга хэмжээ 4.15. Иргэн гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан нийгмийн оролцоогоо хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх "Иргэний хяналт" платформ хөгжүүлнэ. | - | Платформын тоо | 0 | 1 | Ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан. Түүнчлэн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/93 тушаалаар Иргэн гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан нийгмийн оролцоогоо хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх "Иргэний хяналт" платформ хөгжүүлэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулж, тендер зарласан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 68 | Арга хэмжээ 4.16. "Токенжуулсан хувьцаа" төслийг боловсруулна. | - | Төслийн тоо | 0 | 1 | Ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | |
| **Зорилт 5. Цахим орчинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөв зохистой хэрэглээний соёлыг нэвтрүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулах, иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх** | | - | **Арга хэмжээний тоо** | **0** | **1** | **Байгууллагын тоо-17<br>Нэвтрүүлсэн системийн тоо-0<br>Сургалтын тоо-0** | |
| 69 | Арга хэмжээ 5.1. Албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Байгууллагын тоо | 0 | 305 | 2025 оны жилийн эцсийн байдлаар 3007 байгууллага албан бичиг солилцооны дундын системд холбогдсон байна. Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаартай тушаалаар байгуулсан.<br>Энэхүү ажлын хүрээнд төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 21 аймагт зохион байгуулж, сургалтын агуулгад албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээний талаар тусгасан. Сургалтад төрийн 3,161 албан хаагч хамрагдсан. Албан бичиг солилцооны дундын системд 17 байгууллагын 3,008 байгууллага холбогдож, 332,841 бичиг илгээж, 379,140 бичиг хүлээн авч, 468,189 файл дамжуулсан байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 70 | Арга хэмжээ 5.2. Сонсголын бэрхшээлтэй, хараaны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хиймэл оюуны хөрвүүлэгч систем нэвтрүүлнэ. | - | Нэвтрүүлсэн системийн тоо | 0 | 1 | Ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталж, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/124 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан. Тендерийг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр нээсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 71 | Арга хэмжээ 5.3. Тусгай хэрэгцээт иргэдийн цахим ур чадварыг сайжруулах сургалтыг зохион байгуулна. | - | Сургалтын тоо | 0 | 1 | Ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| **Яамны стратегийн зорилт 3. Гарааны бизнесийн эко системийг дэмжих, инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортод гаргах замаар цахим эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр урт, дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах.** | | | | | | | |
| **Зорилт1. Нийгэм эдийн засгийг инновац шингэсэн технологиор хөгжүүлэх, инновац шингэсэн технологиудыг нутагшуулах, турших, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах.** | | - | Төслийн тоо<br>Грант олгосон төслийн тоо<br>Арга хэмжээний тоо<br>Судалгааны тоо | 0 | 3 | **Судалгааны тоо 1**<br>**Хүргүүлсэн баримт бичгийн тоо 1**<br>**Боловсруулсан баримт бичгийн тоо 1**<br>**Арга хэмжээний тоо 3**<br>**Сургалтын тоо 1**<br>**Нэр томьёоны лавлахын тоо 1** | |
| 72 | Арга хэмжээ 1.1. "Шинэ Хархорум" хотод "Орхоны хөндий"-д өндөр технологи, инновац, бизнес хөгжлийн төв байгуулах судалгаа хийнэ. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд "Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төслийн ажил хийж гүйцэтгэх" ажлын тендерийг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан.<br>Тус үйлчилгээний ажлын даалгаварт заасны дагуу бүс орон нутгийг үнэлэх судалгаагаар Мэдээллийн | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах байршлыг "Шинэ Хархорум" хотын "Орхоны хөндий"-д биш Архангай аймагт байгуулах нь үр дүнтэй гэж дүгнэсэн.<br>Уг судалгаанд үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаалаар эдгээр хабуудыг байгуулах бүсийн байршлыг Архангай, Ховд, Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Хэнтий аймгуудад байгуулахаар тогтоосны дагуу эдгээр байршлуудад ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна. | |
| 73 | Арга хэмжээ 1.2. Инновацын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ. | - | Судалгааны тоо | 0 | 1 | "Инновацын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх" ажлын даалгаврыг баталсан. Тус ажлыг Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгээс хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлсэн. | 100 |
| 74 | Арга хэмжээ 1.3. Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | "Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2026-2030)"-ийг боловсруулахтай холбогдуулан тус тэргүүлэх чиглэлд санал авахаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 02/2308 дугаартай албан бичгийг Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн. Энэ хүрээнд 13 Засгийн газрын гишүүнээс нийт 108 санал ирснийг нэгтгэн "Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2026-2030)" боловсруулах ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэж байна. | 30 |
| 75 | Арга хэмжээ 1.4. Инновац, мэдээллийн технологийн паркийн талаар судалгаа хийж, цаашид баримтлах бодлогыг боловсруулж, бүс, орон нутагт парк байгуулахад тавигдах шаардлагыг тодорхойлно. | - | Бодлогын баримт бичгийн тоо<br><br>Тавигдах шаардлагын тоо | 0<br><br>0 | 1<br><br>1 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бүс орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ зорилтын хүрээнд "Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төслийн ажил хийж гүйцэтгэх" ажлын хүрээнд мэдээллийн технологийн хаб/хамтын оффисыг бүс болгонд байгуулахтай холбоотой судалгааны эхлэлийн тайланг хүлээн авч танилцсан. Судалгаанд үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаалаар уг хабуудыг байгуулах бүсийн байршлыг тогтоосон. Дээрх тогтоосон байршлуудыг Засаг дарга | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нартай хамтран ажиллаж, хаб байгуулах нөхцөл шаардлага, эскиз зургийг боловсруулж байна. | |
| 76 | Арга хэмжээ 1.5. Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын болон тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн төслийн тоо | 0 | 1 | "Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх, инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/832 дугаар албан бичгээр Засгийн газрын гишүүд, нийслэлийн Засаг дарга нараас санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01/1029 дугаартай албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 05 дугээр сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор батлагдсан. | 100 |
| 77 | Арга хэмжээ 1.6. "ICT экспо 2025" арга хэмжээг зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн болон салбарын хувийн хэвшлийн байгууллагуудын дунд салбар хэлэлцүүлэг, "ICT EXPO-2025" үзэсгэлэнг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг тус яамны сайдын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулсан.<br>Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "ICT ЭКСПО 2025" арга хэмжээг зохион байгуулах ЦХИХХЯ/20250103113 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/113 дугаар тушаалаар байгуулсан. Тус нээлттэй тендер шалгаруулалтыг 05 дугаар сарын 09 болон 06 дугаар сарын 18-ны өдрүүдэд тус тус зарласан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон.<br>Үүнтэй холбогдуулан 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр болсон НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байгаа "Тогтвортой хөгжилд хиймэл оюуныг ашиглах нь: Монгол Улсын тогтвортой дижитал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирээдүйн бодлого, чадавх, оролцоогоор дэмжих нь" төслийн Удирдах зөвлөлийн хуралдааны хурлын шийдвэрийн дагуу төслийн хүрээнд "ICT EXPO-2025" арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.<br>Энэ хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 19-өөс 26-ны хооронд технологийн 7 хоног буюу "Techweek 2025" арга хэмжээг олон талт хамтын ажиллагаатай зохион байгуулсан бөгөөд энэ хугацаанд нийт 70 гаруй арга хэмжээг хийсэн. Түүнчлэн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр "ICT Forum-2025" арга хэмжээг Төрийн ордны Их танхимд зохион байгуулж, "Digital first" уриан дор Технологийн, Бодлогын зэрэг салбар хэлэлцүүлгүүдийг хийсэн. | |
| 78 | Арга хэмжээ 1.7. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж буй дрон жолоодлогын Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | 2025 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Дрон жолоодлогын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах" ажлын даалгаврыг баталсан боловч, Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 79 | Арга хэмжээ 1.8. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ний сургалт зохион байгуулна. | - | Сургалтын тоо | 0 | 1 | "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн сургалт зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603127 дугаартай үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаалын дагуу 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Дижиталсервис" ХХК-тай Г/04 дугаартай гэрээг байгуулан 2025 оны 02 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус сургалт нь дроны талаарх онолын мэдлэг, техникийн бэлтгэл, нислэгийн дадлага гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдсэн бөгөөд дроны бүтэц, нислэгийн үндсэн зарчим, аюулгүй ажиллагааны дүрэм гэсэн сэдвүүдээр нийт 8 цагийн сургалтыг Хонхорын радио нэвтрүүлэх төв станцын байршилд хийсэн. Сургалтад оролцогчид нислэгийн дадлага хийж, автомат болон гараар удирдах техникийг туршин үзсэн бөгөөд анхан шатны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцогчид дрон хөөргөх, буулгах, энгийн зураг авахад харин дунд шатны оролцогчид илүү нарийн маршрутын дагуу бартаат нислэг үйлдэж, салхины нөхцөлд тэнцвэр хадгалах, тусгай зорилгоор бичлэг хийх зэрэг чадварыг эзэмшүүлсэн. | |
| 80 | Арга хэмжээ 1.9. Дрон жолоодлогын сургалт хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулна. | - | Гарын авлагын тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/47 дугаар тушаалаар "Сургалтын тогтолцоо бий болгох, зэрэг дэв олгох, санал боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Уг хурлаар "Дроны жолоодлогын сургалт хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулах" ажлын даалгаврын төслийг танилцуулан тус яамны 2025 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан. Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан. Тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны зарласан боловч амжилтгүй болсон тул дахин 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зарлан үнэлж, МУИС-ийн Бизнесийн сургуультай 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч байгууллагаас ажлын эцсийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр ирүүлсэн бөгөөд уг тайланг хянан авч баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсгээс өгсөн санал, зөвлөмжийг тусган сайжруулж, гүйцэтгэгч байгууллагаас эцсийн тайланг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр хүлээн авсан бөгөөд гэрээг дүгнэж гарын авлгыг хүлээн авсан. | 100 |
| 81 | Арга хэмжээ 1.10. Дэвшилтэт Технологийн нэр томьёоны лавлах гаргана. | - | Нэр томьёоны лавлахын тоо | 0 | 1 | Дэвшилтэт технологийн нэр томьёоны лавлах гаргах ажлыг "Системийн инженерчлэлийн институт" ГҮТББ-тай 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Ү/14 дүгээр гэрээ байгуулан гүйцэтгүүлж тайлан "Нэр томьёоны лавлах"-г хүлээн авсан. | 100 |
| 82 | Арга хэмжээ 1.11. Монгол улсын инновацын тогтолцооны гүйцэтгэлийг үнэлэх олон улсын судалгааны аргачлалыг | - | Судалгааны тоо | 0 | 1 | "Монгол Улсын инновацын тогтолцооны гүйцэтгэлийг үнэлэх олон улсын судалгааны аргачлалыг нутагшуулж, мэдээллийн технологийн болон өндөр технологийн салбарт инновацын судалгаа хийх" ажлын даалгаврыг баталж, тендер шалгаруулалтыг зохион | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нутагшуулж, мэдээллийн технологийн болон өндөр технологийн салбарт инновацын судалгаа хийнэ. | | | | | байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог 2025 оны А/133 дугаар тушаалаар байгуулсан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон | |
| 83 | Арга хэмжээ 1.12. Шилдэг инновацын төсөл шалгаруулах хөтөлбөрийг орон даяар зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг боловсруулан Сайдын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/88 дугаартай тушаалаар батлуулж, сонгон шалгаруулалтын ажлыг эхлүүлсэн.<br>Сонгон шалгаруулалтын зарын 06 дугаар сарын 18-нд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж, 2 үе шаттай зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад нийт 55 инновацын шийдэл бүхий төсөл оролцоноос 8 төсөл нь тэргүүлэх чиглэлтэй нийцээгүй, 1 төсөл жилийн борлуулалтын орлогын үзүүлэлтээс хэтэрсэн тул нийт 49 төсөл сонгон шалгаруулалтад оролцсон. Эцсийн сонгон шалгаруулалтаар удирдамжид заасны дагуу хамгийн өндөр оноо авсан 14 оролцогчийг шилдгээр шалгаруулан Сайдын 08 дугаар сарын 01-ний өдрийн А/120 дугаар, Төрийн нарийн бичгийн даргын 08 дугаар сарын 18-ны өдрийн А/242 дугаар тушаалаар инновацын грант олгох төслүүдтэй гэрээ байгуулан тус бүр 20'000'000 төгрөгийн грант олгосон. | 100 |
| 84 | Арга хэмжээ 1.13. Электроник, автоматжуулалтын салбарын бодлогын судалгаа хийх, стратеги боловсруулна. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | "Электроникс, автоматжуулалтын салбарын бодлогын судалгаа хийх, стратеги боловсруулах" ЦХИХХЯ/20250603079 дугаартай үйлчилгээний шууд худалдан авалтын ажлыг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/132 дугаар тушаалаар 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр "Хүрээ санал шийдэл" ХХК-тай байгуулсан Ү/13 дугаартай гэрээний | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу ажлын явцын тайланг хүлээн авсан. Энэхүү тайлан нь Монгол Улсын электроникийн салбарыг хөгжүүлэх нарийвчилсан замын зургийг 2025-2030 он хүртэл тодорхойлж, одоогийн сорилтуудыг шийдвэрлэх, стратегийн боломжуудыг ашиглах замаар эдийн засаг, технологи, нийгмийн хөгжилд томоохон ахиц авчирна. Хэрэв амжилттай хэрэгжвэл Монгол Улс дэлхийн электроникийн зах зээлд тогтвортой байр суурь эзэлж, технологийн тэргүүлэгч орнуудын нэг болох боломжтой. | |
| 85 | Арга хэмжээ 1.14. Инновацыг шинэ санааг хөгжүүлэх бүх насны иргэдэд зориулсан 10 цуврал контент хийнэ. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | "Инновацлаг санааг хөгжүүлэх бүх насны иргэдэд зориулсан 10 цуврал бичлэг, нэвтрүүлэг, материал бүтээх" ЦХИХХЯ/20250103089 дугаартай тендер шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооноос 05 дугаар сарын 05-ны өдөр цахим системд нийтлэн зарласан. Тендерийг 05 дугаар сарын 26-ны өдөр нээхэд оролцогчгүй байсан тул 05 дугаар сарын 29-ний өдөр дахин зарласан. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 86 | Арга хэмжээ 1.15. Салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийг практик мэдлэг мэдээллийг оюутнуудад заах боломжийг бүрдүүлж цагийн багш хөтөлбөр боловсруулах, судалгаа хийнэ. | - | Судалгааны тоо | 0 | 1 | "Салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийг практик мэдлэг мэдээллийг оюутнуудад заах боломжийг бүрдүүлж цагийн багш хөтөлбөр боловсруулах, судалгаа хийх" ЦХИХХЯ/20250203090 үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/139 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Дийг Ай Ти" ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлж, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулж, судалгааны эцсийн тайланг 07 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Энэ хүрээнд тус яамны 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/243 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэгчээс эцсийн тайланг хянан авч, баталгаажуулахтай холбоотой саналыг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлж, эцсийн тайланг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт үйлдэн судалгааг хүлээн авсан. | |
| 87 | Арга хэмжээ 1.16. Салбарын судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг хангах, тэдний чанарыг сайжруулах зорилгоор цалинтай PhD доктор хөтөлбөрийг боловсруулна. | - | Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо | 0 | 1 | "Салбарын судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг хангах, тэдний чанарыг сайжруулах зорилгоор цалинтай PhD доктор хөтөлбөрийг боловсруулах" ажлын даалгаврыг баталсан. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 88 | Арга хэмжээ 1.17. Мэдээллийн технологийн ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэдээллээ солилцох, шинэ технологи, инновацтай танилцах боломжийг олгосон Мэдээллийн технологийн ажилтны өдөрлөгийг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан өдөрлөгийн тоо | 0 | 1 | Монгол Улсад орчин цагийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар үүсч хөгжсөний 104 жилийн ойн хүрээнд салбарын хөгжил, "Цахим шилжилт"-ийн бодлогыг хэрэгжүүлж буй талаар Засгийн газар, холбогдох яамны зүгээс онцолж, олон улсын хамтын ажиллагаагаа тэлж, дижитал эдийн засгийг хөгжүүлэх зорилготой арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.<br>Үндсэн үйл явдал ба онцлох зүйлс:<br>• 104 жилийн ой тэмдэглэлт: 2025 онд энэхүү түүхэн ой тохиож, салбарын ололт амжилтыг тэмдэглэсэн.<br>• Засгийн газрын бодлого: Монгол Улсын Засгийн газар харилцаа холбоо, мэдээллийн технологийг эдийн засгийн тэргүүлэх салбар гэж зарлаж, "Digital first" уриатай ажиллаж байна.<br>• Цахим шилжилт: "ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРХЭМЛЭГЧ" ЗАСГИЙН ГАЗАР байх зорилт тавьж, Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт болон дижитал эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэж байна.<br>• Олон улсын хамтын ажиллагаа: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь Тажикистан, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Киргиз улсуудтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, Төв Азийн зах зээлд гарах боломжийг нээсэн. <br>• Стратеги: Уул уурхайгаас гадна оюун ухааны экспорт хийх боломжийг нэмэгдүүлэх зорилготой. 104 жилийн ой нь Монголын цахим хөгжлийн шинэ шатыг илэрхийлж, олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой өдөрлөг болсон. | |
| 89 | Арга хэмжээ 1.18. "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны хөгжил-2025" бүсийн зөвлөгөөн зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Зүүн бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд цахим технологийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох, зүүн бүс нутагт ажиллаж байгаа салбарын мэргэжилтэн, албан хаагчдын санал санаачилгыг дэмжих, санал хүсэлтийг бодлого, арга хэмжээнд тусган ажиллах зорилгоор "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын зүүн бүсийн чуулга уулзалт"-ыг Хэнтий аймгийн төв Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Чуулганаар зүүн бүсэд тулгарч буй нийгмийн асуудлыг дижитал технологи нэвтрүүлэн шийдвэрлэх, орон нутгийн бизнест дижитал шийдлийг нэвтрүүлэх, орон нутгийн гарааны бизнесийг хөгжүүлэх зэрэг асуудлаар форум хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн чуулганы үеэр "Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах", "Зүүн бүсийн логистикийн төв байгуулах" санамж бичгүүд зурагдаж, зүүн бүсийн 45 суманд төрийн үйлчилгээний КИОСК машиныг гардуулах, Хиймэл Оюуны илч "1000 AI Ambassador" хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан. | 100 |
| 90 | Арга хэмжээ 1.19. Бүсчилсэн хөгжлийн цахим сургалт хэлэлцүүлэг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо | 0 | 1 | "Бүсчилсэн хөгжлийн цахим сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603124 дугаартай үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/53 дугаар тушаалын дагуу "Норт шүр" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Ү/02 дугаартай гэрээ байгуулсан. Арга хэмжээний хөтөлбөрийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 4 сэдвийн хүрээнд сургалт хийгдсэн бөгөөд 2025 оны 03 дугаар сарын 19- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ний өдөр 3 сэдвийн хүрээнд сургалт явуулсны дараа хэлэлцүүлгийг танхимаар 250, цахимаар 200 гаруй оролцогчдын дунд зохион байгуулж, санал солилцсон. | |
| 91 | Арга хэмжээ 1.20. Мэдээлэл технологийн Улсын олимпиад зохион байгуулна. | - | Зохион байгуулсан улсын олимпиадын тоо | 0 | 1 | Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Мэдээллийн технологийн улсын олимпиад зохион байгуулах" ажлын даалгаврыг баталсан. Ажлын даалгаврын дагуу шууд худалдан авалтын хэлбэрээр гүйцэтгэгчийг сонгож, холбогдох тушаал болон гэрээг батлуулан гэрээний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд уг олимпиадыг амжилттай зохион байгуулахад оролцож, гэрээ дүгнэх актыг баталгаажуулан холбогдох санхүүжилтийг олгосон.<br>Мэдээллийн технологийн улсын олимпиад (Улсын программчлалын 33 дугаар олимпиад)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд Монгол Улсын Боловсролын их сургуульд зохион байгуулсан. Уг олимпиадад нийт 7 сургуулийн 11 багийн 33 оюутан оролцон 2 өдрийн турш 6 бодлогыг шийдвэрлэх программ бичиж өрсөлдөж, онооны эрэмбээр алтан медаль 1, мөнгөн медаль 2, хүрэл медаль 3, шагналт тусгай байр 2, шагналт байр 3-ыг тус тус шалгаруулсан. | 100 |
| **Зорилт 2. Хиймэл оюун ухаан, их өгөгдөл зэрэг дэвшилтэт технологид тулгуурлан нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэхэд салбар хоорондын уялдааг хангах** | | - | Төслийн тоо<br>Нэвтрүүлсэн үйлчилгээний тоо<br>Хүргүүлсэн баримт бичиг | 0<br>0<br>0 | 2<br>2<br>1 | **Арга хэмжээний тоо 2<br>Судалгааны тоо 1<br>Боловсруулсан баримт бичгийн тоо 2** | |
| 92 | Арга хэмжээ 2.1. Хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксын журмыг Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн журмын тоо | 0 | 1 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6.1.6-д заасны дагуу "Хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбокс орчны зохицуулалтын журам"-ын төслийг боловсруулан шууд худалдан авалтыг зохион байгуулж, тайланг хүлээн аван, акт үйлдсэн. Журмыг Засгийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | 60 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, 2025 оны 01 дүгээр сарын 17-ноос 02 дугаар сарын 05-ны өдрүүдэд төр, хувийн хэвшлийн байгууллага, банк, финтек, шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачид, үүрэн холбооны оператор болон их, дээд сургуулийн нийт 500 орчим төлөөлөлтэй 6 удаагийн уулзалтуудыг зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн дүн шинжилгээ хийсний дүнд уг стратегийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. | |
| 93 | Арга хэмжээ 2.2. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Мөн их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалж стратегийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийсэн. Уг суурь судалгаанд үндэслэн "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийг, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хамт эцэслэн боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2103 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Мөн Засгийн газрын 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр уг стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусган баталсан. | 100 |
| 94 | Арга хэмжээ 2.3. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/172 дугаар тушаалаар байгуулагдсан Хиймэл оюун ухааны стратеги төлөвлөгөө боловсруулах, олон улсын дээд хэмжээний арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 2025 оны 1 дүгээр сарын 22, 27, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 02 дугаар сарын 05, 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулсан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. | |
| | | | | | | -Тус яамнаас 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 02/1117 дугаартай албан бичгээр их дээд сургууль, Шинжлэх ухааны академи, Монголын санхүүгийн технологийн холбоо ГҮТББ, Монголын банкны холбоо ГҮТББ, Үүрэн холбооны оператор компаниудад хэлэлцүүлэгт урьж, 05 дугаар сарын 19-ний өдөр "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийг эцэслэх цуврал хэлэлцүүлгийн эхний хэлэлцүүлгийг ШУА-ийн эрдэмтэн, их дээд сургуулийн багш, судлаач нарт, хоёрдугаар хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр арилжааны банк, финтекийн холбооны гишүүд, үүрэн холбооны оператор компаниудад, 3 дахь хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр стартап компаниудын дунд зохион байгуулсан. Түүнчлэн тус стратегийн төслийг салбар бүрийг хамруулан, нийгэм, эдийн засгийн салбаруудын саналыг тусгах зорилгоор нийт 10 удаагийн хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. | |
| 95 | Арга хэмжээ 2.4. Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо, судалгаа хийнэ. | 100.0 Урсгал зардал | Судалгааны тоо | 0 | 1 | -Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүний үр дүнд нийгмийн даатгалын мэдээллийн сан, нийгмийн халамжийн мэдээллийн сан, хүн амын өрхийн мэдээллийн сан, мал тооллогын мэдээллийн сан, бизнес регистрийн мэдээллийн сан зэрэг 5 өгөгдлийн сангийн мета өгөгдөл дээр боловсруулалт хийсэн.<br>-Мэдээллийн сан тус бүрээс 1 сая мөр өгөгдлийн регистрийн дугаарыг шифрлэлтийн арга ашиглан татан авч, хоорондын нийцтэй байдал, мэдээлэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулах хурд зэргийг C, Python, Go зэрэг 3 төрлийн программчлалын хэл дээр амжилттай туршсан. Мөн их өгөгдлийн сан үүсгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд Үндэсний дата төв УТҮГ нь 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн.<br>-Мэдээлэл хариуцагч байгууллагууд тодорхойлох боломжгүй болгосон өгөгдлийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулах, өгөгдлийн агуулахад нийлүүлэх шийдлийг гаргаж, архитектур шийдлийн дагуу сервисийг хөгжүүлсэн.<br>-Өгөгдөл хувиргах хэрэгслийг суулгаж, тохируулах гарын авлага, хувиргасан өгөгдлийг ХУР системээр дамжуулах зааврыг тус тус боловсруулсан.<br>Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр "Их өгөгдлийн (big data) сан"-г үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх техникийн нөхцөл бүрдсэн. Харин их өгөгдлийн сан үүсгэхэд шаардлагатай техник хангамж болон программ хангамжийн зардал нь 7,7 тэрбум төгрөг болох тооцоо судалгаа гарсан бөгөөд санхүүжилтийг шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 96 | Арга хэмжээ 2.5. Хиймэл оюуны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулна. | - | Баримт бичгийн тоо | 0 | 1 | Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах" ЦХИХХЯ/20250203067 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороог 2025 оны А/83 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Дижитал воркс" ХХК-ийг шалгаруулан мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компани гүйцэтгэлийн тайланг ирүүлж, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн. | 100 |
| 97 | Арга хэмжээ 2.6. Хиймэл оюунд суурилсан "Виртуал багш" системийг хөгжүүлнэ. | - | Системийн тоо | 0 | 1 | Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсантай холбоотой уг ажил хийгдээгүй. | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 98 | Арга хэмжээ 2.7. Хиймэл оюуны хөгжүүлэлтийн төв байгуулах ажлын даалгавар боловсруулна. | - | Баримт бичгийн тоо | 0 | 1 | “Хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн төв байгуулах ажлын даалгавар боловсруулах” ажлын даалгаврын дагуу “Эй ай ризирч” ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Y/03 дугаартай гэрээг байгуулж, тайланг авсан. Тайлангийн хүрээнд уг төв нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа 2050”-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн ач холбогдол бүхий санаачилга бөгөөд энэхүү төв нь шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог бэхжүүлж, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, олон улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах боломжтой. Мөн стратегийн ач холбогдол, эдийн засгийн боломжууд, нийгмийн үр ашиг, технологийн чадавхын хөгжил, сорилт бэрхшээл, олон улсын хамтын ажиллагаа, урт хугацааны өгөөж зэргийг боловсруулан гаргаж өгснөөс гадна зөвлөмж хэсэгт 6 шийдэл бөгөөд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг гаргасан байна. | 100 |
| 99 | Арга хэмжээ 2.8. Өгөгдлийн хакатон зохион байгуулна. | - | Зохион байгуулсан хакатоны тоо | 0 | 1 | Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсантай холбоотой төсөв татагдаж уг ажлыг 2025 онд зохион байгуулах боломжгүй болсон. | 30 |
| 100 | Арга хэмжээ 2.9. Хиймэл оюуны Улсын олимпиад зохион байгуулна. | - | Зохион Улсын олимпиадын тоо | 0 | 1 | “Хиймэл оюуны Улсын олимпиад зохион байгуулах” ЦХИХХЯ/20250603108 дугаартай үйлчилгээний Y/11 дугаартай гэрээг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Монгол Улсын Их Сургуулийн Мэдээллийн Технологи, Электроникийн сургуультай байгуулсан. Уг гэрээний хүрээнд www.kaggle.com платформыг ашиглан олимпиадыг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд нэгдүгээр шатыг 2025 оны 05 дугаар сарын 02-14-ний хооронд цахимаар, хоёрдугаар шатыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр танхимаар тус тус явуулсан. Уг олимпиадад нийслэл, орон нутгаас нийт 272 сурагч бүртгүүлэн оролцсоноос нэгдүгээр шатанд 91, хоёрдугаар шатанд 50 сурагч тус тус хамрагдсан. Хоёрдугаар шатнаас шалгарсан 8 сурагч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хиймэл оюуны олон улсын II олимпиадад оролцохоор тодорсон.<br>Хиймэл оюуны олон улсын хоёрдугаар олимпиадыг (MAIO 2025) БНХАУ-ын Бээжинд 2025 оны наймдугаар сард зохион байгуулж, Монгол Улс хоёр баг, 8 сурагчаар төлөөлүүлэн оролцож, хүрэл медаль хүртсэн бөгөөд машин сургалт, хиймэл оюуны бодлогууд хэлэлцэгдэж, технологийн паркуудаар аялсан чухал арга хэмжээ болсон. | |
| **Зорилт 3. Мэдээллийн технологи, программ хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны бизнесийг дэмжих** | | - | ТЭЗҮ-тоо<br>Өөвлөлгөөний тоо<br>Арга хэмжээний тоо<br>Үйлчилгээний тоо<br>Байгууллагын тоо | 0 | 1<br>1<br>1<br>1<br>5 | **Хүргүүлсэн журмын төслийн тоо 2** | |
| 101 | Арга хэмжээ 3.1. Инновац, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулна. | - | Судалгааны тоо<br><br>Зураглалын төслийн тоо | 0<br><br>0 | 1<br><br>1 | "Инновац, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулах" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/264 дугаар тушаалаар байгуулагдсан "Инновац, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулах" ЦХИХХЯ/20250203101 дугаартай ажлыг "Ашид ассет менежмент" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/264 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дээрх ажлын эцсийн тайланг хянан авч, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр хуралдан тайлантай танилцаж, санал боловсруулан гүйцэтгэгчид хүргүүлсний дагуу 10 дугаар сарын 08-ны өдөр гүйцэтгэгчээс сайжруулан ирүүлсэн эцсийн тайланг хянан баталгаажуулсан. Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн тайлан хүлээн авч акт үйлдсэн. | 100 |
| 102 | Арга хэмжээ 3.2. "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, | - | Хүргүүлсэн журмын төслийн тоо | 0 | 1 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.7-д заасны дагуу "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам"-ын төслийг боловсруулан Мэдээллийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | виртуал бүсийн ажиллах журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. | | | | | технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн. Засгийн газрын тогтоолын төсөл, журмын танилцуулгын хамт боловсруулж, нийт 22 Засгийн газрын гишүүд, сайдад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1009, 07 дугаар сарын 03-ны өдрийн 01/1592 дугаар албан бичгийг тус тус хүргүүлж, ирүүлсэн саналуудыг нэгтгэн журмын төслийг эцэслэж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 01/2055 дугаар албан бичгээр бичгийг хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2025 оны 98 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн ажиллах журам"-ыг батлагдсан. | |
| 103 | Арга хэмжээ 3.3. "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн журмын төслийн тоо | 0 | 1 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13.4-т заасны дагуу "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулан, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн. Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 01/2055 дугаар албан бичгээр бичгийг хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 98 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ыг батлагдсан. | 100 |
| 104 | Арга хэмжээ 3.4. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформ хөгжүүлнэ. | - | Платформын тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформыг хөгжүүлэх" ажлын даалгаврыг баталсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэгчдийн бүртгэлийн нэгдсэн платформ хөгжүүлэх" ЦХИХХЯ/20250202083 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулах үнэлгээний хороог | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10 дугаар сарын 02-ны өдрийн А/275 дугаар тушаалаар байгуулан, тендерийг 10 дугаар сарын 06-ны өдөр зарласан. Тус тендерт 3 оролцогч материал ирүүлснийг Үнэлгээний хороо 11 дүгээр сарын 04-ний өдөр хуралдан сонгон шалгаруулалт хийсэн. Тус тендер шалгаруулалтад нэг оролцогчоос гомдол гарган гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор Сангийн яамнаас үйл ажиллагааг түр түтгэлзүүлсэн. Сангийн яамнаас гарсан гомдол үндэслэлтэй байна гэсэн шийдвэр гарсны дагуу Үнэлгээний хороо дахин үнэлгээ хийхэд шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул бүх тендерээс татгалзсан. Үүнтэй холбогдуулан Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААҮТГ-тай хамтран e-business системээр дамжуулан 2026 оны 01 дүгээр сараас эхлэн хуулийн этгээдийг бүртгэхээр бэлтгэл ажлыг хийж байна.<br>Түүнчлэн Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 98 дугаар тогтоолын 1 дэх заалтаар "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс"-ийг байгуулах шийдвэрийг гаргуулсан. Энэ хүрээнд Мэдээллийн технологийн үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих виртуал бүсийг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төслийг боловсруулсан. | |
| 105 | Арга хэмжээ 3.5. Дроны туршилтын төв байгуулах ажлыг эхлүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/48 дугаар тушаалаар "Дроны туршилтын бүс байгуулах техник, эдийн засгийн судалгаа хийх, холбогдох хууль тогтоомжийн дагуу туршилтын бүс байгуулах" үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Уг хурлаар туршилтын бүс байгуулахтай холбоотой ажлын явцыг танилцуулж, цаашид хийх ажлын талаар санал солилцсон. Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын санхүүжилтээр хийгдэхээр тусгагдсан "Дроны туршилтын бүсийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах" ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, дээрх хүрээлэнд хүргүүлсэн боловч, нээлттэй зарласан хугацаанд төсвийн | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодотголоор төсөв танагдсантай холбоотой уг ажил санхүүжилтгүй болж зогссон.<br>Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2025 оны 1/381 албан тоотоор ирүүлсэн байршлуудыг 2025 оны 04 дүгээр сард Харилцаа холбооны зохицуулах хороонд радио давтамжийн харилцан нөлөөллийн хэмжилт дүгнэлт гаргуулсан бөгөөд дээрх 2 байршил нь туршилтын бүс байгуулахад намгархаг, дэд бүтцээс хол байсан тул дахин байршил ~~сонгох процессыг хийхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд~~ Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас дахин ирүүлсэн байршлуудад 2025 оны 8 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд ХХЗХ-оор дахин хэмжилт хийлгүүлж, дүгнэлт гаргуулсан. | |
| 106 | Арга хэмжээ 3.6. МХХТ-ийн салбарын бизнес эрхлэгч, гарааны бизнесүүдэд ээлтэй, хууль, эрхзүй, санхүүгийн тогтвортой орчныг бүрдүүлэх "Business friendly Mongolia" хөтөлбөр боловсруулна. | - | Хөтөлбөрийн тоо | 0 | 1 | "МХХТ-ийн салбарын бизнес эрхлэгч, гарааны бизнесүүдэд ээлтэй, хууль, эрхзүй, санхүүгийн тогтвортой орчныг бүрдүүлэх "Business friendly Mongolia" хөтөлбөр боловсруулах" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог 2025 оны А/159 дүгээр тушаалаар байгуулсан. | 30 |
| 107 | Арга хэмжээ 3.7. Өндөр хөгжилтэй орнуудын гарааны бизнес, хөрөнгө оруулалт, өндөр технологи, инновацын талаарх шинэ мэдлэг, мэдээлэл, ноу-хау импортлох, нутагшуулах ажлыг зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | "Өндөр хөгжилтэй орнуудын гарааны бизнес, хөрөнгө оруулалт, өндөр технологи, инновацын талаарх шинэ мэдлэг, мэдээлэл, ноу-хау импортлох, нутагшуулах" ЦХИХХЯ/202501030899 дугаартай тендер шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 05 дугаар сарын 01-ний өдөр цахим системд нийтлэн зарлаж, 05 дугаар сарын 23-ны өдөр нээсэн. Нэг оролцогчтой байсан боловч тухайн оролцогч шаардлага хангаагүй тул 05 дугаар сарын 29-ний өдөр дахин зарласан бөгөөд шалгаруулалтад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй. Улмаар 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан төсөв танагдсан тул дахин зарлаагүй. | 30 |
| 108 | Арга хэмжээ 3.8. Гарааны бизнес, инновацын талаар мэдлэг, соёлыг түгээн | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | "Гарааны бизнес, инновацын талаар мэдлэг, соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах" ажлын даалгаврыг баталсан. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| - | дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | | | | | Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсантай холбоотой худалдан авах ажиллагаа зогсоосон. | |
| 109 | Арга хэмжээ 3.9. Монголын гарааны бизнесийн санхүүжилтийн хүртээмж судалгаа хийнэ. | - | Судалгааны тоо | 0 | 1 | "Монголын гарааны бизнесийн санхүүжилтийн хүртээмж судалгаа" ЦХИХХЯ/20250603106 дугаартай үйлчилгээний шууд худалдан авалтын ажлыг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны А/174 дүгээр тушаалаар 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр У/18 дугаартай гэрээг байгуулан, эцсийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн. | 100 |
| **Яамны стратегийн зорилт 4. Харилцаа холбоо, радио давтамж, хиймэл дагуул, шуудан, өргөн нэвтрүүлэг, сансрын технологийн орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нутагшуулах, төсөл хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах** | | | | | | | |
| **Зорилт 1. Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг хангана.** | | - | Ажлын хэсгийн тоо, Туршилтын тоо | **0** | **2**<br>**1** | **Санал 3**<br>**Ажлын даалгавар 1**<br>**Гэрээ байгуулсан 1**<br>**Дахин зарлах тендер 2** | |
| 110 | Арга хэмжээ 1.1. Харилцаа холбооны шугам сүлжээ, дэд бүтцийг хот төлөвлөлт, эрчим хүч, зам, замын барилга байгууламж, зэрэг инженерийн дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөнө. | - | Саналын тоо | 0 | 2 | "Шинэ Хархорум" хотын мэдээлэл холбооны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлын үнэтэй танилцаж, саналыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03/385 дугаар албан бичгээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн.<br>Шинэ Хархорум бүтээн байгуулалтын үндэсний хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд харилцаа холбооны сүлжээний дэд бүтцийн талаарх саналыг цахимаар 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Шинэ Хархорум захирагчийн Ажлын албанд хүргүүлсэн.<br>Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаварт оруулах харилцаа холбооны сүлжээний дэд бүтцийн талаарх саналыг цахимаар 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн. | 100 |
| 111 | Арга хэмжээ 1.2. Улс хоорондын транзит урсгалыг нэмэгдүүлэх, шинэ гарц бий | - | Судалгааны тоо | 0 | 1 | Ажлын даалгаврын төслийг боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр баталсан. Улсын төсвийн | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болгох эрх зүйн зохицуулалт, зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа хийнэ. | | | | | тодотголоор тухайн төсөл арга, хэмжээний төсөв хасагдсан тул гүйцэтгэх боломжгүй болсон. | |
| 112 | Арга хэмжээ 1.3. Харилцаа холбооны хээрийн дэд бүтцийн нэг маягийн зураг төсөл, төсөв боловсруулна. | - | Баримт бичгийн тоо | 0 | 1 | "Харилцаа холбооны хээрийн дэд бүтцийн нэг маягийн зураг төсөл, төсөв боловсруулах" 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ЦХИХХЯ/20250203017 дугаартай гэрээт ажлын хүрээнд Ажлын зураг төсөв, Магадлалын дүгнэлт холбогдох бичиг баримт, Нийслэлийн онцгой байдлын газрын Галын аюулгүй байдлын магадлал хийсэн тухай дүгнэлтийг баталгаажуулан 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 25/191 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Холбогдох материалыг шалгаж, гэрээ дүгнэх маягтыг баталгаажуулсан. | 100 |
| 113 | Арга хэмжээ 1.4. IoT (Internet of Things) болон Digital twin технологийг нэвтрүүлэх судалгаа хийнэ. | - | Судалгааны тоо | 0 | 1 | Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | 30 |
| 114 | Арга хэмжээ 1.5. Харилцаа холбооны салбарын (мобайл станц, шилэн кабель, шуудан) нэгдсэн дата бааз байгуулах, real time AI-д суурилсан систем нэвтрүүлнэ. | - | Системийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/102 дугаар тушаалаар тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулж, тендерийг цахим системээр 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр нээлттэй зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр нээсэн. Уг тендерт 2 оролцогч материал ирүүлсэнийг хянан үзэхэд захиалагчийн шаардлага хангаагүй байх тул тэдгээр тендерээс татгалзсан бөгөөд 2025 оны улсын төсөвт тодотгол хийж, шаардагдах санхүүжилтийг хассан тул тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах боломжгүй болсон. | 30 |
| 115 | Арга хэмжээ 1.6. Харилцаа холбооны цамхгийн металл хийцийн ядралын зэрэг тогтоох, үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулна. /Харилцаа холбооны дэд бүтцийн хэвийн найдвартай ажиллагааг хангах/ | - | Үзлэг шалгалтын тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/144 дугаар тушаалаар "Харилцаа холбооны цамхгийн металл хийцийн ядралын зэрэг тогтоох, үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулах /харилцаа холбооны дэд бүтцийн хэвийн найдвартай ажиллагааг хангах/" ЦХИХХЯ/20250201022 тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулж, | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч тендер амжилтгүй болсон. 2025 оны улсын төсөвт тодотгол хийж, шаардагдах санхүүжилтийг хассан тул тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах боломжгүй болсон. | |
| **Зорилт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар харилцаа холбооны сүлжээ өргөтгөх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | - | Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тоо, хэрэгжилтэд хяналт хийх төсөл, арга хэмжээний тоо | 0 | 10<br>5<br>3<br>1<br>3<br>8 | **Дэд бүтэц байгуулах цэгийн хайгуул хийлгүүлэх байршил 46**<br>**Хяналт хийх 5** | |
| 116 | Арга хэмжээ 2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх харилцаа холбооны сүлжээ өргөтгөх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавин, ашиглалтад хүлээн авна. /Улсын хэмжээнд/ | - | Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо | 0 | 35 | Төсөл, арга хэмжээний нэг маягийн зургийн ажлын даалгаврыг Барилгын хөгжлийн төвийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан бөгөөд нэг маягийн зургийг магадлангаар батлуулах шатандаа явж байна. Оператор компаниудаар дэд бүтэц байгуулах цэгийн хайгуул хийлгүүлэн 46 байршлыг гаргуулан төслийн гүйцэтгэгч нарт албан бичгээр баталгаажуулан хүргүүлсэн.<br>Улсын хэмжээнд харилцаа холбооны сүлжээг өргөтгөх төсөл, арга хэмжээний хүрээнд нэг маягийн зургийн даалгаврыг баталгаажуулж, магадлалын дүгнэлтийг батлуулан, нийт 15 байршилд харилцаа холбооны сүлжээний байгууламжийг барьж байгуулсан. | 100 |
| 117 | Арга хэмжээ 2.2. Үүрэн холбооны сүлжээ сайжруулах станц /Хөвсгөл, Эрдэнэбулган, Галт, Түнэл, Жаргалант, Баянзүрх сум/ байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавин, ашиглалтад хүлээн авна. | - | Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо | 0 | 5 | Энэхүү төслийн хүрээнд 5 байршилд харилцаа холбооны дэд бүтцийг байгуулж, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллан, үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэн үйлчилгээг эхлүүлсэн. | 100 |
| 118 | Арга хэмжээ 2.3. Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Бөхмөрөн, Өмнөговь, Баруунтуруун сум/ байгуулан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт | - | Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо | 0 | 3 | Увс аймгийн Бөхмөрөн, Өмнөговь, Баруунтуруун сумдад баригдах үүрэн холбооны дахин дамжуулах станцын барилга угсралтын ажил бүрэн баригдаж дууссан. 2025 оны 06 дугаар сард байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж барилга байгууламжийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавин, ашиглалтад хүлээн авна. | | | | | ашиглалтад оруулж, үүрэн холбооны үйлчилгээг эхлүүлсэн. | |
| 119 | Арга хэмжээ 2.4. Шилэн кабельд холбох, зураг төсөв /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/ шилжих Багц-5 боловсруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавин, ашиглалтад хүлээн авна. | - | Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо | 0 | 1 | Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулна /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ төслийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 08 дугаар сард ажиллаж, 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн ББКД-83-03/25 дугаартай комиссын дүгнэлт гарсан. Тус ажлын санхүүжилтийн материалыг хянан шалгаж 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 02/2137 дугаартай албан бичгээр "Санхүүжилтийн эрх нээлгэх тухай" хүсэлтийг Сангийн яам руу хүргүүлсэн. | 100 |
| 120 | Арга хэмжээ 2.5. Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц байгуулах /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/ төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавина. | - | Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо | 0 | 3 | Увс аймгийн Улаангом, Сагил, Тариалан сумдад үүрэн холбооны дахин дамжуулах станцын барилга байгууламж баригдаж дуусан ба газрын зөвшөөрөл олголтын процессоос шалтгаалж байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаагүй. | 70 |
| 121 | Арга хэмжээ 2.6. Үүрэн холбооны сүлжээ байгуулах /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дадал, Дархан, Баянмөнх, Баянхутаг сум/ төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавина. | - | Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо | 0 | 4 | Хэнтий аймгийн Норовлин, Галшар, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дадал, Дархан, Баянмөнх, Баянхутаг сумдад үүрэн холбооны дахин дамжуулах станцын ажлын тендер шалгаруулалттай холбоотой шүүхэд гарсан гомдлын улмаас төслийг бүхэлд нь хүчингүй болгох шүүхийн процесс явагдаж байгаа тул уг ажил зогссон. | 0 |
| **Зорилт 3. Үндэсний радио давтамжийн нөөцийг үр ашигтай, зүй зохистой ашиглах, хуваарилах ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг хангана.** | | - | **Баримт бичгийн тоо тайлангийн тоо** | **1** | **1** | **1** | |
| 122 | Арга хэмжээ 3.1. Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-ийг шинэчлэн боловсруулна. | - | Баримт бичгийн тоо | 1 | 1 | Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж гаргасан.<br>Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлтийг шинэчлэх судалгааны хүрээнд олон улсын судалгааг хийсэн. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 123 | Арга хэмжээ 3.2. Радио долгионы тухай хуулийг дагаж гарсан захиргааны хэм хэмжээний актуудад дүн шинжилгээ хийнэ. | - | Судалгааны тоо | 1 | 1 | Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй (ЗГХЭГ-ын 2025.05.13-ны ХЭГ/1370 албан бичгээр ирүүлсэн) холбогдуулан Радио долгионы тухай хуульд оруулах зөвшөөрөлтэй холбоотой асуудлын төслийг судалж, холбогдох мэдээллийг хүргүүлж, 05 дугаар сарын 22, 29-ний уулзалтад оролцож, хүргүүлсэн саналын талаар хэлэлцсэн.<br>Радио долгионы тухай хуулийг дагаж гарсан захиргааны хэм хэмжээний 4 актад дүн шинжилгээ хийж холбогдох саналыг тухай бүр боловсруулж хүргүүлж ажилласан. | 100 |
| **Зорилт 4. Хил залгаа улстай радио долгионы асуудлыг зохицуулна.** | | - | **Координацын тоо** | **25** | **20** | **16** | |
| 124 | Арга хэмжээ 4.1. Хөрш орнуудтай байгуулсан хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын гэрээний хэрэгжилтийг хангана. | - | Координацын тоо | 25 | 20 | ОХУ, БНХАУ, Казакстан Улсын холбогдох яамдтай хил орчмын радио давтамжийн зохицуулалтын координацыг тухай бүр хийсэн: 1. ОХУ-тай нийт **23** удаагийн координац хийсэн. 2. БНХАУ-тай 2 удаагийн координац хийсэн. 3. Казакстан улстай **7** удаагийн координац хийсэн.<br>1. Хил орчмын радио давтамжийн зохицуулалтын гэрээний дагуу ОХУ-ын Радио давтамжийн төвөөс ирүүлсэн газрын хөдөлгөөнт холбооны 4 станцын, хөдөлгөөнт бус үйлчилгээний 9 станцын, VHF/FM өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний 1 станцын, хиймэл дагуулын газрын 2 станцын, нийт **16** станцын координац хийсэн.<br>2. Замын-Үүд боомтод БНХАУ-ын талаас 2500-2600 МГц радио давтамжийн зурваст үүсгэж байгаа радио давтамжийн харилцан нөлөөллийн талаарх **1** мэдэгдлийг БНХАУ-ын талд 2025.05.14-ний өдрийн MDDIC/03/78 албан бичгээр, хэмжилтийн тайлангийн хамт хүргүүлсэн. 3.Казакстан улсаас ирүүлсэн хиймэл дагуулын газрын станцын координац хийх тухай **3** албан хүсэлтэд холбогдох хариуг тухай бүр хүргүүлсэн. | 90 |
| **Зорилт 5. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлнэ.** | | - | Баримт бичгийн тоо<br>Координацын тоо | -<br>22<br>1<br>7 | 1<br>20<br>1<br>1 | **Ажлын хэсэг 1**<br>**Координацын тоо 4** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэлэлцсэн асуудлын тоо<br>Хурлын тоо<br>Саналын тоо | 0 | 2 | | |
| 125 | Арга хэмжээ 5.1. Сансрын тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | - | Хуулийн төслийн тоо | Хуулийн тандан судалгаа хийгдсэн | 1 | 1.ЦХИХХ-ны Сайдын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар Ажлын хэсгийг байгуулсан.<br>2.Салбарын хэмжээнд ажлын хэсэг байгуулахаар ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02/1232 дугаартай албан бичгээр Ажлын хэсэгт орох нэрсийг 32 байгууллагаас авахаар хүргүүлсэн боловч яамны бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөж ажлын хэсгийг байгуулаагүй болно. | 0 |
| 126 | Арга хэмжээ 5.2. Монгол Улсад хуваарилагдсан сансрын холбооны хиймэл дагуулын радио давтамжийн хуваарилалт, орбитын байрлалыг хамгаалах ажлыг зохион байгуулна. | - | Координацын тоо | 7 | 5 | Монгол Улсад хуваарилагдсан сансрын холбооны хиймэл дагуулын радио давтамжийн хуваарилалт, орбитын байрлалыг хамгаалах ажлыг тогтмол хийж байна. Дэлхийн радио холбооны дүрмийн дагуу хөөргөсөн болон хөөргөхөөр төлөвлөж буй хиймэл дагуулын радио давтамжийн координацийн талаарх албан хүсэлтийн хүрээнд Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас 7 албан бичиг ирүүлснийг судалж, хариуг ЦХИХХЯ-ны ТНБД-ын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн MDDIC/03/09, 05 дугаар сарын 07-ны өдрийн MDDIC/03/76, 06 дугаар сарын 09-ний өдрийн MDDIC/03/81, MDDIC/03/82, 07 дугаар сарын 07-ны өдрийн MDDIC/03/88, 11 дүгээр сарын 20-ны өдрийн MDDIC/03/143, MDDIC/03/144 дугаартай албан бичгээр ОУЦХБ-д хүргүүлсэн. | 100 |
| 127 | Арга хэмжээ 5.3. Сансрын бодлогын Үндэсний зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна. | - | Хуралдааны тоо | 2 | 2 | 1."Сансрын үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулан санал авахаар Сансрын үндэсний зөвлөлийн гишүүдэд албан мэйлээр хүргүүлсэн.<br>2. Ирүүлсэн саналыг нэгтгэн Сансрын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг хангасан. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөж Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор Сансрын бодлогын үндсэний зөвлөлийг татан буулгасан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 128 | Арга хэмжээ 5.4. Үндэсний хиймэл дагуул хөөргөж ашиглах чиглэлээр сонирхогч байгууллагуудтай хамтран ажиллана. | - | Хамтран ажилласан байгууллагын тоо | 1 | 1 | 1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/11 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 05 дугаар сарын 02, 09-ний өдрүүдэд зохион байгуулж хурлын тэмдэглэлийг гаргаж ажлын хэсгийн гишүүдээр гарын үсэг зурж баталгаажуулсан.<br>2.Монгол, Францын Засгийн газар хоорондын ажлын хэсгийн 3 дугаар хуралдааны үед манай талаас баримтлах байр суурийн талаар Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төсөлтэй холбоотой мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн. | 50 |
| 129 | Арга хэмжээ 5.5. Монгол Улсад хуваарилагдсан хиймэл дагуулын байрлалд хиймэл дагуулын сүлжээний төлөвлөлтийг боловсруулан ОУЦХБ-д хүргүүлнэ. | - | Хиймэл дагуулын сүлжээний төлөвлөлтийн тоо | 2 | 3 | "Chinggis-2" хиймэл дагуулын төлөвлөлтийг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ОУЦХБ-д хүргүүлсэн. Олон улсын хиймэл дагуулын сүлжээний төлөвлөлтийн мэдээлэл буюу BR-IFIC 3050 дугаарт 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хэвлэгдэж Казакстан, ОХУ, БНФУ, Малта, БНЭУ, Швед улсаас зөвшилцөл хийх хүсэлт ирүүлсэн. CHINGGIS-3 хиймэл дагуулын төлөвлөлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр ОУЦХБ-руу e-communication системээр хүргүүлсэн. Олон улсын хиймэл дагуулын сүлжээний төлөвлөлтийн мэдээлэл буюу BR-IFIC 3056 дугаарт 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хэвлэгдсэн. | 100 |
| 130 | Арга хэмжээ 5.6. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын төсөл хөтөлбөрийн зохицуулалт хийнэ. | - | Төсөл хөтөлбөрийн тоо | 1 | 1 | 1.Ази, Номхон далайн орнуудын сансрын хамтын ажиллагааны байгууллагаас зарласан төсөл хөтөлбөрт Монгол Улсаас 4 төслийн саналыг хүргүүлж 2 төслийг "Төлөвлөгөөний жагсаалт"-д оруулсан.<br>2.Шинжлэх Ухааны Академийн харьяа Одон орон геофизикийн хүрээлэнд Телескоп суурилуулах ажилд хамтран ажиллаж Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 131 | Арга хэмжээ 5.7. Тандан судалгааны агаарын бөмбөлөг хөөргөх, гелий хийн зардлын тооцоолол боловсруулна. | - | Баримт бичгийн тоо | 0 | 1 | Монгол хүн сансарт ниссэн ойн өдрийг тохиолдуулан сансар судлалыг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор "Тандан судалгааны агаарын бөмбөлөг хөөргөх, гелийн хийн зардлын тооцоолол боловсруулах ЦХИХХЯ/20250603020" арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж Ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр баталж "Монголын сансрын судалгаа хөгжүүлэлтийн төв" НҮТББ, "Монголын гео-мэдээллийн холбоо" ТББ, "Монголын сансрын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | технологийн холбоо" ТББ гэсэн гурван байгууллагад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03/553 дугаартай албан бичгээр урилга хүргүүлсэн. Монголын Сансрын судалгаа хөгжүүлэлтийн төв НҮТББ-тай 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Ү/04 дугаартай гэрээг байгуулсан. "Тандан судалгааны агаарын бөмбөлөг хөөргөх, гелийн хийн зардлын тооцоолол боловсруулах ЦХИХХЯ/20250603020" ажлыг 2025 оны 03 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан. | |
| 132 | Арга хэмжээ 5.8. Сансарын төв байгуулах урьдчилсан судалгаа хийнэ. | - | Судалгааны тоо | 0 | 1 | ЦХИХХЯ-ны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний 11 дүгээрт байгаа "Сансрын төв байгуулах урьдчилсан судалгаа хийх" тухай Ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр баталсан. Тус судалгааны ажилд урьж буй талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 02/877 дугаартай албан бичгийг "БАЯСАХ БӨӨДӨР" ХХК, "ЗОРИГТ ИТГЭЛД ГЭРЭЛ НЭМЬЕ" НҮТББ, "MN PARTNERS" гэсэн 3 байгууллагад хүргүүлсэн. Үйл ажиллагааны чиглэл тааραагүй тул гэрээ байгуулах боломжгүй байсан. Дахин 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 02/2056 албан бичгээр 3 байгууллагад урилга хүргүүлж "Монголын сансрын технологийн холбоо" ГҮТББ-аас ирүүлсэн саналыг судалж тус байгууллагатай Ү/25 дугаартай гэрээг байгуулж судалгааны ажлыг гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 133 | Арга хэмжээ 5.9. Сансарын долоо хоног арга хэмжээ зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | ЦХИХХ-ны сайд Монгол хүн сансарт ниссэний 44 жилийн ойн өдрийг тохиолдуулан анхны сансрын нисэгчийг бэлтгэх, нислэгийн өмнө болон дараа нь судалгаа хийж ажиллаж байсан ШУА-ийн эрдэмтэд болон сансрын нисэгч Ж.Гүррагчаа нарын 8 ахмадыг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авч уулзалт хийх ажлын зохион байгуулалтыг хийсэн. | 100 |
| 134 | Арга хэмжээ 5.10. MARS V төсөл цахим сургалт зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Яамны төсөвт тусгагдсан уг арга хэмжээг зохион байгуулах зардал нь буцаан татагдсан тул тус арга хэмжээ зохион байгуулагдаагүй. | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 6. Шуудан, цахим худалдааны чиглэлээр шинэ техник, технологийг нэвтрүүлэх, шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн талаар төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | | - | Холбосон платформын тоо<br>Арга хэмжээний тоо | - | 2 | Батлуулсан баримт бичгийн тоо-0<br>Арга хэмжээний тоо-1<br>Хүргүүлсэн хуулийн төслийн тоо-100 | |
| 135 | Арга хэмжээ 6.1. Шуудангийн нэгдсэн код оноох аргачлалыг шинэчлэн боловсруулж батална. | - | Батлуулсан баримт бичгийн тоо | 1 | 1 | ЦХХХЯ-ны 2023 оны А/226 тушаалаар Шуудангийн нэгдсэн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журмын төслийг боловсруулах, шуудангийн нэгдсэн кодыг шинэчлэн оноох ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. ЦХИХХ-ны Сайдын 2024 оны 09 сарын 30-ны өдрийн "Шуудангийн нэгдсэн код шинэчлэн батлах тухай" А/24 тушаалаар Монгол Улсын Шуудангийн нэгдсэн кодын жагсаалтыг баталж, зохион байгуулалтыг Харилцаа холбооны зохицуулах хороо хариуцан ажилласан. Дээрх тушаалын тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тушаалын хэрэгжилтийн тайланг ХХЗХ-оос авсан. Засгийн газрын 2007 оны 200 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бүсчиллийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам"-ийг шинэчлэхтэй холбоотой санал боловсруулж ажилласан. Хаягжуулалтийн тухай хууль батлагдсаны дараагаар журмын төслийг тус хуульд нийцүүлэн боловсруулж, батлуулахаар төлөвлөсөн. | 70 |
| 136 | Арга хэмжээ 6.2. Дэлхийн шуудан холбооны Ази Номхон далайн бүс нутгийн холбооны Гүйцэтгэх зөвлөлийн хурал (Executive Council Meeting) -ыг Монгол улсад зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | "Дэлхийн шуудан холбооны Ази номхон далайн бүс нутгийн холбооны гүйцэтгэх зөвлөлийн хурал"-ын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгч "Монгол шуудан" ХК-тай ЦХИХХЯ/20250203123 дугаартай гэрээ байгуулан ажиллаж, хурлыг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хооронд "Туушин хотел"-д амжилттай зохион байгуулсан. Гүйцэтгэгчээс хурал зохион байгуулсан гүйцэтгэлийн материалыг ирүүлснийг хянан баталгаажуулж, санхүүжилтийг шийдвэрлэсэн. | 100 |
| 137 | Арга хэмжээ 6.3. Хаягжуулалтын тухай | - | Хүргүүлсэн хуулийн төслийн тоо | 0 | 1 | Хаягжуулалтын тухай хуулийн төсөлд тусгах саналаа боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/164 дугаартай албан бичгээр Газар зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн төсөл боловсруулж Засгийн газарт хүргүүлнэ. | | | | | байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлж, тус газрын мэргэжилтэнтэй хамтран ажилласан. ГЗБГЗЗЕГ-аас дээрх хуулийн төслийг эцэслэн боловсруулж, 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1/2475 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| **Зорилт 7. Радио, өргөн нэвтрүүлгийн системийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.** | | - | **Арга хэмжээний тоо** | **0** | **6** | **Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр-5**<br>**Хяналт шалгалтын тайлангийн тоо-4** | |
| 138 | Арга хэмжээ 7.1. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна. | - | Баталсан төлөвлөгөө, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо | 10 | 16 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г батлуулсан.<br>Уг төлөвлөгөөнд заасан 6 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог 2025 оны А/35, А/42 дугаар тушаалаар тус тус батлуулсан. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын даалгавруудыг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр баталж, тендерийн баримт бичгийг боловсруулж, нийт 6 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулж, тендер хянан үзэх, үнэлэх үнэлгээний хороог төсөл арга хэмжээ тус бүрээр хуралдуулж, 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 5 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг дахин зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Дэлхийн чимээ медиа групп ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр "Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэн хүргэх" ЦХИХХЯ/20250103008 дугаартай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | 70 |
| 139 | Арга хэмжээ 7.2. "Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний хяналтын журам"-ын хэрэгжилтийг хангуулна. | - | Хяналт, шалгалтын тайлангийн тоо | 0 | 4 | "Сансрын холбооны кей юу (KU) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хүрээнд тус яамны сайдын 2022 оны 02 сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан "Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналтын журам"-ын хоёрдугаар хэсгийн дагуу Нэгдүгээр улирлын хэмжилт, шалгалтыг 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр, Хоёрдугаар улирлын хэмжилт, шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдөр, Гуравдугаар улирлын хэмжилт, шалгалтыг 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр, Дөрөвдүгээр улирлын хэмжилт, шалгалтыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр МХС ТӨК-ийн Наран станцад байрлах /МОНГОЛСАТ НЭТВОРКС ХХК/ газрын станцад улирал бүр хяналт хийж тухай бүр тайлан гаргаж хэрэгжилтийг хангасан. | |
| **Зорилт 8. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг хангаж ажиллана.** | | - | Батлагдсан төлөвлөгөө Хэрэгжсэн төслийн тоо | 1 0 | 1 0 | 1 6 | |
| 140 | Арга хэмжээ 8.1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээг дуусгах, 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулна. | - | Баталсан төлөвлөгөө, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо | 1 2 | 1 10 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/12 дугаар тушаалаар "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ"-ний төлөвлөгөөг баталсан.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны А/45 дугаар тушаалаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж, батлагдсан төлөвлөгөөний хүрээнд нийт 10 төсөл арга хэмжээнээс 6 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулж, тендер хянан үзэх, үнэлэх үнэлгээний хороог төсөл арга хэмжээ тус бүрээр хуралдуулж, "Сангийн хөрөнгөөр сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргах", "Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй хүн ам, газар нутгийн талаарх зах зээлийн нөхцөл байдлын судалгааг хийлгэх", "Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг алслагдсан бүс нутагт турших, нэвтрүүлэхэд шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж (30 цэг)", "Харилцаа холбооны сүлжээ хүрээгүй алслагдсан багт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх (40 хүртэлх баг)" төслийн 3 багц, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх (182 сум)", "Үүрэн холбооны үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор эрчим хүчний саатал ихтэй алслагдсан багт байрших бааз станцын нөөц тэжээлийн эх үүсвэрийг шинэчлэх (10 сайт)" төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. | |
| **Яамны стратегийн зорилт 5. Кибер аюулгүй байдлыг хангах асуудлыг нэгдсэн бодлого төлөвлөлтөөр хангах, хэрэгжилтийг зохион байгуулах** | | | | | | | |
| **Зорилт 1. Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулна.** | | - | Засгийн газрын тогтоолын төслийн тоо<br>Шалгалт хийсэн байгууллагын тоо<br>Зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тоо<br>Шалгалт хийсэн байгууллагын тоо<br>Судалгааны тоо<br>Зааварчилгааны тоо<br>Судалгааны тоо<br>Үнэлгээний тоо | 0<br>0<br>4<br>0<br>1<br>1<br>0<br>0 | 1<br>34<br>10<br>3<br>1<br>1<br>1<br>1 | **Аудит хийх зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тоо 46 КАБ эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тоо 33** | |
| 141 | Арга хэмжээ 1.1. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад тавигдах шаардлагыг тодорхойлж, жагсаалтыг шинэчлэн боловсруулна. | - | Засгийн газрын тогтоолын төслийн тоо | 0 | 1 | ЦХИХХЯ-ны 2025 оны А/105 дугаар тушаалаар онц чухал мэдээлллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, жагсаалтыг шинэчлэхэд оролцогч талуудын саналыг тусгахаар 2025 оны 05 дугаар сарын 15-нд Онц чухал мэдээллийн дэд бүтцийн кибер аюулгүй байдал сэдэвт семинар зохион байгуулж, тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө боловсруулах болон байгууллагын хэмжээнд кибер эрсдэлийг тодорхойлох, удирдах талаар мэдлэг олгож, дасгал ажилласан. Энэхүү арга хэмжээнд нийт 83 байгууллагын 115 албан хаагч оролцож, 57.7 хувь нь онц чухал мэдээллийн дэд бүтцийг байгууллагын нэрээр бус салбар, үйл ажиллагааны чиглэлээр нь тодорхойлохыг санал болгосон. Мөн кибер аюулгүй | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлын хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд онц чухал мэдээллийн дэд бүтцийг салбараар нь гаргахыг зөвлөмж болгосон. Засгийн газрын тогтоолоор байгууллагын жагсаалтыг шинэчлэх бус Кибер аюулгүй байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд энэхүү саналыг тусгахаар ажлын хэсгээс дүгнэсэн. | |
| 142 | Арга хэмжээ 1.2."Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-ын хэрэгжилтийг хангуулна. | - | Шалгалт хийсэн байгууллагын тоо<br>Бүртгэж, зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тоо | 0<br>34 | 34<br>37 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 09-00/10 дугаартай Хяналт шалгалтын удирдамжийг үндэслэн мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөлтэй 39 байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 18-ны өдрүүдийн хооронд хийсэн.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/16, 17, 18, 19, 20 дугаартай тушаалаар, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/40 дугаартай тушаалаар, 2025 оны 04 дүгээр сарын А/62, 63 дугаартай тушаалаар, 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/107, 109, 110, 111 дугаартай тушаалаар, 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/123 дугаар тушаалаар нийт 13 байгууллагад Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл олгосон. Нийт 46 байгууллага зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. | 100 |
| 143 | Арга хэмжээ 1.3. "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"-ын хэрэгжилтийг хангуулна. | - | Бүртгэж, зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тоо | 4 | 10 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33 дугаартай тушаалаар, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/41 дугаартай тушаалаар, 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/64, 65, 66, 67, 68, 69, 70, 71, 72 дугаартай тушаалаар, 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/77, 78 дугаартай тушаалаар, 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/102, 103, 104, 105, 106 дугаар тушаалаар, 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/139, 140 дугаартай тушаалаар нийт 33 байгууллагад Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 144 | Арга хэмжээ 1.4. Тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийж, дүгнэлт гаргана. | - | Шалгалт хийсэн байгууллагын тоо | 0 | 3 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 09-00/14 Хяналт шалгалтын удирдамж батлагдсан. Тус хяналт шалгалтыг 2025 оны 12 дугаар сарын 22-ноос 26-ны өдрүүдийн хооронд зохион байгуулсан. | 100 |
| 145 | Арга хэмжээ 1.5. Үндэсний хэмжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцооны суурь судалгаа хийх, аюулгүй байдлыг шалгах зааварчилгаа боловсруулна. | - | Судалгааны тоо<br>Зааварчилгаа-ны тоо | 0<br>0 | 1<br>1 | Монгол Улсын Үндэсний кибер эрсдэлийг тодорхойлох судалгааг Их Британийн Засгийн газартай хамтран 2025 оны 09 дүгээр сараас 12 сарын хооронд хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Үндэсний кибер эрсдэлийг тодорхойлох судалгааг 2025 оны 10 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү судалгаанд онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 25 байгууллага хамрагдаж, дотоодын баг нууцын баталгаа гаргасны үндсэн дээр байгууллага бүрээр кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан бэлтгэж, зөвлөмж гаргаж байна. Төслийн хүрээнд Их Британийн кибер аюулгүй байдлын экспертүүд Монгол Улсад биечлэн ирж, Үндэсний кибер эрсдэлийг тодорхойлох арга аргачлал, тайлан, зөвлөмж боловсруулах талаар сургалт хийсэн. Мөн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл бүхий байгууллагуудад, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүдийн эрсдэлийн үнэлгээ хийх, тайлан хүлээн авах чиг үүргийг хариуцсан албан хаагчдад нийт 2 удаагийн сургалт хийж, мэдээлэл солилцсон. | 100 |
| 146 | Арга хэмжээ 1.6 Кибер халдлага, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх систем хөгжүүлэх тооцоо судалгаа хийх, системийг нэвтрүүлнэ. | - | Судалгааны тоо<br>Системийн тоо | 0<br>0 | 1<br>1 | Кибер халдлага, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх систем хөгжүүлэх тооцоо судалгааг хийх ажлын даалгаврыг боловсруулсан. Санхүүжилтгүйн улмаас энэ ажил хийгдээгүй. | 30 |
| 147 | Арга хэмжээ 1.7. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт нөлөөллийн үнэлгээ хийнэ. | - | Үнэлгээний тоо | 0 | 1 | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт нөлөөллийн үнэлгээ хийх ажлын гүйцэтгэгчээр "Дийг Ай Ти" ХХК шалгарсан. Тус байгууллагаас ирүүлсэн тайлан шаардлага хангаагүй нэмэлт сайжруулалт хийх шаардлагатай тул Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/234 дүгээр тушаалаар гэрээний хугацааг сунгасан. Мөн Цахим хөгжил, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | инновац, харилцаа холбооны 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/259 дүгээр тушаалаар "Ажил хүлээн авах комисс" байгуулсан. Комиссын хурлыг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Гэрээ дүгнэсэн маягтыг баталгаажуулан 10 дугаар сарын 30-нд хүлээлгэн өгсөн. | |
| **Зорилт 2. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх бүтцийн үйл ажиллагааг сайжруулна.** | | - | Төслийн тоо<br>Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо | 0<br>15 | 1<br>30 | -<br>38 | |
| 148 | Арга хэмжээ 2.1. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийн дэд бүтцийг шинэчлэх төсөл хэрэгжүүлнэ | - | Төслийн тоо | 0 | 1 | Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв УТҮГ-ын кибер халдлагад хариу үзүүлэх чадавхыг үнэлэх судалгааг хамтран зохион байгуулах төслийн саналыг Олон Улсын Цахилгаан Холбооны байгууллагад 2025 оны 06 дугээр сарын 12-нд хүргүүлж, айлын талаас зөвшөөрсөн. Төслийн бэлтгэл ажлыг ханган 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр судалгааны эхний 2 шат болох асуулт хариулт, биечлэн очиж танилцах хэсгийг зохион байгуулсан. Баримт бичгийн дүн шинжилгээнд шаардлагатай нэмэлт материалуудыг 11 сард хүргүүлээд байгаа бөгөөд Нийтийн төвийн чадавхын үнэлгээний тайлан 2025 оны 12 дугаар сарын сүүлээр бэлэн болно. Түүнчлэн, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв дээрх судалгааг хийлгэх хүсэлтээ илэрхийлсэн тул төслийн санал боловсруулж, ГХАХ-ээр дамжуулан ОУЦХБ-д хүргүүлээд байна. | 100 |
| 149 | Арга хэмжээ 2.2. Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулна. | - | Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо | 15 | 30 | Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийн хүрээнд Нийтийн төвийн 4 албан хаагчийг 2025 оны 02 дугаар сарын 7-8, 14-15, 22-ны өдрүүдэд "Хортой кодын шинжилгээ хийх" сургалтад, 4 албан хаагчийг 2025 оны 1 сарын 06-наас 10-ны өдрүүдэд "SOC"-ын сургалтад, 15 албан хаагчийг 2025 оны 08 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Кибер аюулгүй байдлын хууль сэдэв сургалтад, 5 албан хаагчийг 2025 оны 09 дугаар сарын 29-10 дугаар сарын 03-ны өдрүүдэд МТ-ийн суурь дэд бүтцийн аюулгүй байдал сэдэвт сургалтад, 5 албан хаагчийг 2025 оны 10 дугаар сарын 23, 2025 оны 11 дүгээр сарын 27 өдрүүдэд IT Infrastructure Construction Exercise сургалтад, мөн 5 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан хаагчийг 2025 оны 12 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд Digital Forensics and Incident Response (DFIR) сэдэвт сургалтад тус тус хамруулсан. Нийт 6 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 38 албан хаагчийг чадавхжуулсан. | |
| **Зорилт 3. Кибер аюулгүй байдлын Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.** | | **-** | **Хэрэгжилтийн хувь** | **0** | **100** | **100** | |
| 150 | Арга хэмжээ 3.1. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн төлөвлөгөө, түүний шийдвэрийн хэрэгжилтийг хангана. | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаартай тогтоолоор батлагдсан Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний тайланг 1 дүгээр улирал, хагас жил жилийн тайлан гарган хүргүүлсэн. Мөн шаардлагатай тохиолдлуудад мэдээллээр ханган ажилласан. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдсан "Кибер тусгаар тогтнол" форум зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан. Тус форумыг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Боловсролын яаманд 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 03/2738 дугаартай албан бичгээр хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн. Мөн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийн дагуу явцын тайланг Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн. | 100 |
| **Зорилт 4. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадавхыг сайжруулж, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна.** | | **-** | **Арга хэмжээний тоо<br>Зохион байгуулсан семинарын тоо<br>зөвлөмжийн тоо** | **-<br>-<br>-** | **1<br>1<br>1** | **1<br>1<br>1** | |
| 151 | Арга хэмжээ 4.1. "Ази номхон далайн бүс нутгийн кибер | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | "Ази номхон далайн бүсийн кибер сургуулилт 2025" арга хэмжээг 2025 оны 09 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дадлага, сургуулилт 2025" арга хэмжээг зохион байгуулна. | | | | | зохион байгуулахаар Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагатай тохиролцсны дагуу Хамтын ажиллагааны гэрээний төслийг Монгол хэлнээ орчуулж, Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын 4.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамаар хянуулж, гэрээ байгуулах зөвшөөрлийг авсан. Арга хэмжээг зохион байгуулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан. ЦХИХХЯ-ны 2025 оны А/127 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд кибер сургуулилт зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, гаднаас ирэх зочдод зориулсан мэдээллийн гарын авлага боловсруулах, хамтарсан хэвлэлийн мэдээний төслийг боловсруулах, хурлын үйл ажиллагааг айлын талын албан ёсны цахим хуудсаар дамжуулах техникийн бэлэн байдлыг хангах, интернэтийн тасалдалгүй байдлыг хангах зэрэгт хяналт тавьж ажилласан. Мөн ОУЦХБ-тай хамтарсан төлөвлөгөөг боловсруулж, 14 хоног тутам цахимаар хуралдаж, Олон Улсын хурлын үеэр Монгол талаас оролцох илтгэгчдийг тодорхойлох, 4 өдрийн хөтөлбөрийг айлын талтай тохиролцож баталгаажуулан, сургалт, кибер сургуулилтад оролцогчдын бүртгэлийг гаргаж ажилласан. Ази номхон далайн бүсийн 49 улсын 60 гаруй төлөөлөл хүрэлцэн ирсэн бол Монгол талаас эхний өдрийн хуралдаан 200 гаруй төлөөлөл, техникийн болон менежментийн түвшний сургалтад 80 гаруй төлөөлөл хамрагдсан. Кибер сургуулилтад халдлагад хариу үзүүлэх нийт 55 мэргэжилтэн оролцож, ур чадвараа Ази, номхон далайн бүс нутгийн хэмжээнд батлан хариуулж, харилцан суралцах чухал ач холбогдолтой байсан. | |
| 152 | Арга хэмжээ 4.2. Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэ судалгааны үр дүнг танилцуулж, зөвлөмж гаргана. | - | Зохион байгуулсан семинарын тоо,<br><br>Зөвлөмжийн тоо | 0 | 1<br>1 | Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх судалгааг Оксфордын их сургуулийн Кибер аюулгүй байдлын чадавхын үнэлгээний төвтэй хамтран 2024 оны 08 дугаар сараас 2025 оны 02 дугаар сарын хооронд зохион байгуулсан. Судалгааны багаас ирүүлсэн тайлангийн төсөлд холбогдох байгууллагуудаас санал авахаар 2025 оны 01 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулж, ирүүлсэн саналыг нэгтгэн тайлангийн төсөлд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусгасан. Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшнийг үнэлэх судалгааны үр дүнг танилцуулах хурлыг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан. Хурлын бэлтгэл ажлын хүрээнд өмнө судалгаанд оролцсон төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөлд урилга хүргүүлж, олон нийтэд нээлттэй оролцох боломжийг бүрдүүлэх үүднээс шууд дамжуулалтыг зохион байгуулалтыг хангаж ажилласан. Мөн судалгааны тайлангийн Монгол хэл дээрх орчуулгын хувилбарыг гаргаж, Тагнуулын ерөнхий газарт 2025 оны 02/956 тоот албан бичгээр хүргүүлэн хянуулсан. Улмаар Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшин, дараагийн түвшинд хүргэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод хүргэсэн. | |
| 153 | Арга хэмжээ 4.3. Кибер аюулгүй байдлыг хангахад хиймэл оюуныг ашиглах талаар дүгнэлт, зөвлөмж гаргана. | - | Зохион байгуулсан семинарын тоо,<br><br>Зөвлөмжийн тоо | 0 | 1<br><br>1 | 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Гадаад харилцааны яаманд "Хиймэл оюуны хэрэглээ: Кибер аюулгүй байдлын бэлэн байдлын хэмжүүр" семинарыг Английн Оксфордын их сургуулийн баг, Японы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг ЖАЙКА-тай хамтран зохион байгуулсан. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын нийт 100 гаруй мэргэжлийн судлаач, шинжээчдийг хамруулсан. Судалгааны тайлан, зөвлөмжийн төслийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр бэлэн болсон. | 100 |
| **Зорилт 5. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлнэ.** | | - | **Батлагдсан шаардлагын тоо**<br>**Төслийн тоо** | **0**<br>**0** | **1**<br>**1** | **0**<br>**0** | |
| 154 | Арга хэмжээ 5.1. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлагын төслийг боловсруулж, батална. | - | Батлагдсан шаардлагын тоо | 0 | 1 | Нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлагын төслийг боловсруулж, Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад танилцуулж санал авсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 155 | Арга хэмжээ 5.2. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилнэ. | - | Төслийн тоо | 0 | 1 | Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ажлыг Дэлхийн Банкны "Ухаалаг засаг-2" төслийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр ажлын даалгавар болон тендерийн баримт бичгийг боловсруулж, төслийн нэгжид хүргүүлсэн. Тендер шалгаруулалт хүлээгдэж байна. | 30 |
| 156 | Арга хэмжээ 5.3.Тоон гарын үсгийг олон улсад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх төслийг эхлүүлнэ. | - | Төслийн тоо | 0 | 1 | Дэд бүтцийг шинэчилсний дараа төслийг эхлүүлнэ. Тоон гарын үсгийн хэрэглээний өнөөгийн нөхцөл байдал, хэрэглээг нэмэгдүүлэх талаар танилцуулга боловсруулж, 19-ний өдрийн ээлжит хуралдаанд танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор тоон гарын үсгийн хэрэглэгчийн программ хангамжуудыг нэгтгэх, хэрэглэхэд хялбар болгох, танилт нэвтрэлтийн системд тоон гарын үсэг ашиглах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах талаар холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлсэн. | 30 |
| **Зорилт 6. Хүний хувийн мэдээллийг хамгаалах бодлогын хэрэгжилтийг зохицуулна.** | | - | **Батлагдсан баримт бичгийн тоо**<br>**Батлагдсан баримт бичгийн тоо** | **0**<br>**0** | **1**<br>**1** | **I-IV** | |
| 157 | Арга хэмжээ 6.1. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, хадгалах технологид тавигдах шаардлагын төслийг боловсруулж, батална. | - | Батлагдсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, хадгалах технологид тавигдах шаардлагыг боловсруулах ажлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор Хүний эрхийн Үндэсний комисс, болон мэргэжлийн чиг үүргийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн энэ талаар Жайка олон улсын байгууллагын төслийн дагуу япон улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, холбогдох дүрэм журмуудын талаар судалж байна. Мөн ЦХИХХЯ болон Хүний Эрхийн Үндэсний комиссын гишүүн нарын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хамтарсан уулзалтаар Хүний хувийн мэдээлэл хамгаалах асуудлаар хууль эрх зүйн хүрээнд хэрхэн хамтран ажиллах талаар ярилцаж, зөвшилцсөн. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 158 | Арга хэмжээ 6.2. Дуу, дүрсний, дуу дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлагыг батална. | - | Батлагдсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний комиссоос санал авч "Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээлэл"-ийн журмын төслийг 5 бүлэг 17 заалтын хүрээнд Хүний эрхийн Үндэсний комиссоос санал авч тусган боловсруулж дууссан. Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээлэл"-ийн журмыг ЦХИХХСайдын А/06 дугаар тушаалаар баталсан. | 100 |
| **Зорилт 7. Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ.** | | - | Сургалтад хамруулсан багшийн тоо<br>Сургалтын тоо<br>Арга хэмжээний тоо | 0<br>0<br>0 | 24<br>5<br>1 | 24<br>2<br>1 | |
| 159 | Арга хэмжээ 7.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах багш нарыг чадавхжуулах сургалтад хамруулна. | - | Сургалтад хамруулсан багшийн тоо | 0 | 24 | Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийн хүрээнд ШУТИС-ын 9, МУИС-ын 2 багшийг 2025 оны 2 дугаар сарын 7-8, 14-15, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан "Хортой кодын шинжилгээ хийх" сургалтад, мөн ШУТИС-ын 10 багш, МУИС-ын 3 багшийг 2025 оны 01 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулсан "SOC"-ын сургалтад тус тус хамруулсан. Нийт 24 багшийг чадавхжуулах сургалтад хамруулсан байна. | 100 |
| 160 | Арга хэмжээ 7.2. Төрийн байгууллагын болон онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын албан хаагчдад "Кибер аюулгүй байдал"-ын чиглэлээр сургалт зохион байгуулна. | - | Сургалтын тоо | 0 | 5 | Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр "Онц чухал мэдээллийн дэд бүтцийн кибер аюулгүй байдал" сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтаар кибер халдлага, зөрчлийн өнөөгийн байдал, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэхэд анхаарах асуудлуудын талаар танилцуулж, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, байгууллагын тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сэдвийн хүрээнд дасгал ажил хийсэн. Энэхүү арга хэмжээнд нийт 83 байгууллагын 115 албан хаагчид оролцсон. Төрийн байгууллагын удирдах түвшний албан хаагчдад кибер аюулгүй байдлын тухай хууль | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон түүнийг даган гарсан журмуудыг талаар мэдээлэл өгөх, хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар танилцуулах сургалтыг 2025 оны 4 сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Үндэсний кибер эрсдэлийг тодорхойлох судалгааны хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 40 гаруй байгууллагад кибер эрсдэлийн тодорхойлох, түүнийг удирдах талаар сургалт хийсэн. | |
| 161 | Арга хэмжээ 7.3. Бүх нийтийн кибер аюулгүй байдлыг хангах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 оны 04 сарын 02-ны өдөр "Залуучуудын цахим аюулгүй байдал" сэдэвт залуучуудын цахим аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд олон талын оролцоог нэмэгдүүлэх хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, сурагчид нийт 50 гаруй хүн хамрагдсан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Өсвөр үеийнхний цахим аюулгүй байдал" сэдэвт сургалт арга хэмжээг 2025 оны 06 сарын 13-ны өдөр зохион байгуулж, цахим орчинд өөрийгөө хамгаалах талаар мэдээлэл өгсөн. | 100 |
| **Яамны стратегийн зорилт 6. Хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар яамны аппаратыг цомхон, чадварлаг болгон өөрчлөн хөгжүүлэх** | | | | | | | |
| | **Зорилт 1. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд дотоод сургалтын төлөвлөгөөг батлуулах, сургалтыг тухай бүр зохион байгуулахад нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.** | - | Тоо | 1 | 1 | 1 | |
| 162 | Арга хэмжээ 1.1. Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн, хэрэгжилтийг хангана. | - | Хөтөлбөрийн тоо<br>Хэрэгжилтийн тайлан | 1<br>0 | 1<br>1 | Тус яамны "Хөдөлмөрийн дотоод журам", "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр", "Ахмадын санг ажиллуулах журам", "Албан томилолтын журам", "Салбарын шагнал олгоход мөрдөх журам", "Архив, албан хэрэг хөтлөлтийн журам"-ын төслийг чиг үүргийн дагуу боловсруулан батлуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 163 | Арга хэмжээ 1.2. Яамны албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөөний тоо<br>Сургалтын тоо | 0<br>0 | 1<br>1 | Албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/58 дугаар тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг зохих сургалтуудад хамруулсан. | 70 |
| 164 | Арга хэмжээ 1.3. Албан хаагчдын ажлын үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулна. | - | Үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан тоо | 2 | 2 | Засгийн газрыын 2023 оны 301 дүгээр тогтоолын дагуу Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, баталгаажуулах чиг үүрэг бүхий Үнэлгээний багийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар байгуулж, 2025 оны эхний хагас жилийн үнэлгээг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр, 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/334 дүгээр тушаалаар байгуулагдсан Үнэлгээний баг 2025 оны жилийн эцсийн үнэлгээг 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр тус тус зохион байгуулсан. | 100 |
| 165 | Арга хэмжээ 1.4. Албан хаагчдын цахим ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулна. | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 1 | Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыгжил бүр төсвийн төсөлд тусган ажиллаж байна. 2025 оны байдлаар төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, нийт 6 албан хаагчийг өөрийн болон улсын төсвийн санхүүжилтээр суралцуулахаар 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03/106 дугаар албан бичгийг Удирдлагын академид хүргүүлсэн. Мөн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагчийг өөрийн төсвийн санхүүжилтээр суралцуулах хүсэлтийг Удирдлагын академид 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 03/638 дугаар албан бичгээр хүргүүлж, албан хаагчид суралцаж төгссөн. | 100 |
| **Зорилт 2. Төрийн захиргаа, хүний нөөцийн манлайллыг хангах, салбарын албан хаагчдын тэгш байдлыг хангах, салбарын шагнал, хүндэтгэлийн арга хэмжээний нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлнэ.** | | - | Журмын тоо<br>Төлөвлөгөөний тоо<br>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 1<br>0<br>0 | 1<br>2<br>1 | 1<br>2<br>1 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 166 | Арга хэмжээ 2.1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын шагналын журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангана. | - | Шинэчлэн боловсруулсан журмын тоо<br>Олгосон шагналын тоо | 1<br>0 | 1<br>1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/87 дугаар тушаалаар "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын шагнал олгох, шагналын сан бүрдүүлэх журам"-ыг шинэчлэн баталсан. "Дэлхийн мэдээлэлжсэн нийгмийн өдөр"-ийг тохиолдуулан Цахим, хөгжил инновац харилцаа холбооны сайдын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/60 дугаар тушаалаар салбарынхаа хөгжилд оруулсан хувь нэмэр, ажлын амжилт, бүтээлийг нь үнэлэн нэр бүхий инженер, техникийн ажилтан, албан хаагчид, ахмад настанд 34, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ойн баяр, Монгол улсад орчин цагийн цагийн мэдээлэл харилцаа холбооны салбар үүсэж хөгжсөний 104 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан 2025 оны 06 дугаар сарын 12-ны А/99 дүгээр, 2025 оны 06 сарын 24-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар 707 шагнал, Ахмадын баярын өдрийг тохиолдуулан 2025 оны 09 сарын 25-ны өдрийн А/12 дугаар тушаалаар 132 шагнал, Шинэ жилийн баярын өдрийг тохиолдуулан 2025 оны 12 сарын 10-ны өдрийн А/163 дугаар тушаалаар 217 хүнд шагнал олгосон. | 100 |
| 167 | Арга хэмжээ 2.2. Жендерийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Төлөвлөгөөний тоо<br>Хүргүүлсэн тайлангийн тоо | 1<br>0 | 1<br>1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын А/314 дүгээр тушаалаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон хөгжлийн зорилт хөтөлбөр, арга хэмжээ, Жендэрийн үндэсний хорооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий тус яамны дэргэдэх "Жендерийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг шинэчлэн баталсан.<br>-Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/, Жендерийн үндэсний хорооны 2025 оны төлөвлөгөөг үндэслэн 2025 онд хийх ажлын төлөвлөгөө гаргаж, харьяа, салбар газруудад хүргүүлэн тогтоосон хугацаанд тайланг авч нэгтгэн Жендерийн үндэсний хороонд хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -2025 оны 07 сард Монгол Улс дахь "People in need" Олон улсын төрийн бус байгууллагаас Европын холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх нь (DICE-Digital inclusion through CSO Empowernment)" төслийн хүрээнд зарлагдсан дэд төслийн шалгаруулалтад оролцож дэмжлэг авсан "Эмэгтэй удирдагч сан" ТББ-аар ЦХХХСайдын 2023.01.27-ны өдрийн А/05 дугаар тушаалаар баталсан "Харилцаа холбооны салбарт баримтлах жендэрийн стратеги, үйл ажиллагааны чиглэл (2023-2026)-д жендэрийн мониторинг үнэлгээ хийлгэж, салбарын хэрэгцээг тодорхойлон цаашид үйл ажиллагаандаа тусгах санал зөвлөмжийг боловсруулах болон салбарын 10 сургагч багш бэлтгэх бодлогын хэлэлцүүлгүүд зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөн, салбарын жендэрийн мэдрэмжтэй бодлогыг сайжруулах, жендэрийн мэдрэмжтэй цахим дижитал, инновацыг хөгжүүлэх, мэдээлэл зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.<br>-Жендерийн тэгш бус байдал, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бууруулахад залуучууд, олон нийтийн жендерийн боловсролыг нэмэгдүүлэх мэдээ, мэдээллийг түгээх, бодлогын нөлөөллийн аяны хүрээнд харьяа, салбар байгууллагууд цахим хуудаст богино, шторк, контентоор олон нийтэд мэдээлэл түгээсэн. | |
| 168 | Арга хэмжээ 2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орон тооны бус дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Төлөвлөгөөний тоо<br>Хүргүүлсэн тайлангийн тоо | 1<br>0 | 1<br>1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/83 дугаар тушаалаар салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хангахад чиглэсэн хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, харилцаа холбоо, мэдээлэл, технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж,<br>2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 02/1950 дугаар албан бичгээр Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тайланд хийсэн ажиглалт, дүгнэлтийг хүргүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох мэдээ, мэдээлэл, судалгаа тайланг байгууллагын болон харьяа салбарын хэмжээнд нэгтгэн хугацаанд нь хүргүүлсэн.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-т заасан "Өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад нийт ажлын байрныхаа 4 хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна" гэсэн заалтыг хэрэгжүүлж ЦХИХХЯ болон харьяа, салбар байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчийн судалгааг гаргаж хүргүүлсэн. | |
| **Зорилт 3. Гамшгийн үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын бэлэн байдал, тасралтгүй ажиллагааг хангах төлөвлөгөөг баталж, урьдчилан сэргийлэх мэдээг дамжуулах, гамшгийн үеийн бэлэн байдлын дадлага, сургуулилалтыг зохион байгуулна.** | | - | Төлөвлөгөө-ний тоо<br><br>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | **1**<br>**0** | **1**<br>**1** | **1**<br>**1** | |
| 169 | Арга хэмжээ 3.1. Гамшгийн урьдчилан сэргийлэх мэдээг дамжуулах болон гамшгийн үеийн харилцаа холбооны бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангана. | - | Төлөвлөгөө-ний тоо<br><br>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 1<br>0 | 1<br>1 | Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд зохих байршилд 11 галын хор, бусад шаардлагатай хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдад "Объектын гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ" 3-р сард зохион байгуулагдсан дадлага сургалтын үед галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мөн сургалт хийсэн. Төрийн тусгай албанаас тус яаманд галын аюулгүй бэлэн байдлын шалгалтыг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 09 дүгээр сард хийж тус шалгалтаар сайн үнэлгээ авсан. | |
| Зорилт 4. Салбарын санхүү, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтийн нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлнэ. | | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 16 | 16 | 16 | |
| 170 | Арга хэмжээ 4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийг нэгтгэн, боловсруулж УИХ, Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 3 | 3 | -2026 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд урсгал зардалд 140.2 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 125.9 тэрбум төгрөг, нийт 266.1 тэрбум төгрөгийн саналыг боловсруулж Эдийн засаг хөгжлийн яаманд 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/740 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Төсвийн хязгаарын санал урсгал зардалд 200.8 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 88.5 тэрбум төгрөг, нийт 289.4 тэрбум төгрөгийн саналыг боловсруулж Сангийн яаманд 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1386 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>-2026 оны төсвийн төслийг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/1713 дугаартай албан бичгээр Улсын Их Хурал, Сангийн яам, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн. Үүнээс урсгалд зардалд 53.3 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 11.5 тэрбум төгрөгийн санал бүхий 149 хуудас материалыг хүргүүлсэн. 2026 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад урсгал зардал 60.9 тэрбум, хөрөнгийн зардалд 24.8 тэрбум төгрөг батлагдсан. | 100 |
| 171 | Арга хэмжээ 4.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, тайлагнах, гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийн эрх нээлгэх, санхүүжилтийг олгоно. | - | Батлагдсан төсөл, арга хэмжээ, төлөвлөгөөний тоо | 11 | 11 | -Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын 2025 оны хөрөнгө оруулалтын төсөвт 35.7 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс төсөвт тодотгол хийснээр шилжих дөрвөн төсөл, шинээр хэрэгжүүлэх нэг төсөл, арга хэмжээний 23.4 тэрбум төгрөг батлагдсан. Хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, багцын хөрөнгө оруулалтын төсвийг задлах шийдвэрийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01, 01 дүгээр сарын 24-ний А/08 дугаар тушаалаар, мөн эрх шилжүүлэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны А/03, 03 дугаар сарын 21-ний А/51 дугаар тушаалаар тус тус батлуулж, төсвийн хөрөнгө | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оруулалтын цахим системд хуулийн хугацаанд нийтэлсэн.<br>-2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналыг publicinvestment.gov.mn системээр нэгтгэн МУЗГ-ын 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын Маягт-03-ын дагуу баталгаажуулж хүргүүлсэн. /ЦХИХХС-ын хөрөнгө оруулалтад шилжих 4, шинээр хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээний 24.8 тэрбум төгрөг батлагдсан/.<br>-2025 оны 1–12 дугаар сарын хөрөнгө оруулалтын явц, санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээг сар бүр Сангийн яаманд албан бичгээр болон цахим системээр тайлагнасан.<br>-2024 онд ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээллийг МУЗГ-ын 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын Хавсралт 17-д заасан хүснэгтэн мэдээний дагуу нэгтгэн боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/132 дугаар албан бичгээр Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн.<br>-2025 онд хэрэгжиж буй "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/" төслийн 6.84 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, баримт бичгийн бүрдлийг хангуулан санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн.<br>-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 12 төслийн гэрээний ерөнхий нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлт хангагдсан тул ЦХИХХС-ын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/64 дугаартай тушаалаар барьцааг чөлөөлж, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/161, 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 02/852 дугаартай албан бичгээр тус тус Сангийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | яаманд хүргүүлж нийт 171 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээлгэсэн.<br>-2025 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлээс 8.5 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн. /Санхүүжилтийн эрх ирүүлээгүй хүлээгдэж буй гүйцэтгэл 14.8 тэрбум төгрөг/ | |
| 172 | Арга хэмжээ 4.3. Төсвийн шууд захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааг төлөвлөж, 2024 оны худалдан авах ажиллагааг тайлагнана. | - | Батлагдсан төлөвлөгөөний тоо, тайлангийн тоо | 2 | 2 | 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны урсгал зардлын хөрөнгөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г баталсан. Тайлант онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны А/237, А/311 дүгээр тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн нэмэлт, өөрчлөлтийг тус тус оруулсан. 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/, шилэн дансны /shilendans.gov.mn/-ээр дамжуулан хуулийн хугацаанд тайлагнасан. Яам, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сангийн нийт 72 төсөл арга хэмжээнээс 59 төсөл арга хэмжээ гэрээ байгуулан хэрэгжсэн. | 100 |
| **Зорилт 5. Салбарын нягтлан бодох бүртгэл, тайлагналын нэгдсэн зохицуулалтыг хангах, хэрэгжилтийг хангана.** | | - | **Тайлангийн тоо** | **5** | **5** | **3<br>2<br>1** | |
| 173 | Арга хэмжээ 5.1. Төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлнэ. | - | Тайлангийн тоо | 3 | 3 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу иж бүрэн бэлтгэж, мөн хуулийн 8.9.1-т заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 03/185 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлсэн.<br>Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Өргөн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/414 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн аудитын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 02/913 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүгийн 2025 оны эхний хагас жилийн тайланг бэлтгэж 2025 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор албажуулж, Сангийн яамны цахим систем /old-ereport.mof.gov.mn/ шивж илгээн ТЕЗ-ийн тайланд нэгтгүүлсэн. | |
| 174 | Арга хэмжээ 5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж, Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ. | - | Тайлангийн тоо | 2 | 2 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа төсөвт 7, төрийн өмчит 5 байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, холбогдох хоорондын тооцоо, ТСҮАЖ-ын 4 дүгээр зүйлийн дагуу дансны дүн мэдээг тулган баталгаажуулсан. Шууд захирагчдын Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэн, бэлтгэж 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/745 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, 2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/958 дугаар албан бичгээр Сангийн сайдад тус тус хүргүүлсэн. Тайлант онд аудитаар 2 төсвийн шууд захирагч түүвэрт хамрагдсан, 5 шууд захирагч хязгаарлалттай, 5 шууд захирагч өөрчлөлтгүй дүгнэлт авсан. ТЕЗ-ын 2025 эхний хагас жилийн тайланг нэгтгэн бэлтгэж, 01/1879 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| 175 | Арга хэмжээ 5.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитаар баталгаажуулан, Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгүүлнэ. | - | Тайлангийн тоо | 1 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланг Монгол Улсын Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхээр 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/958 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийн хооронд Монгол Улсын Засгийн газрын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгтгэсэн тайлангийн аудитын хуулийн хугацаанд холбогдох тайлбар тодруулга, судалгаа мэдээллийг боловсруулан тухай бүр цахимаар хүргүүлж ажилласан. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон "Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолтой холбогдуулан Төсвийн зарлагын дэд хороо, Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралд шаардлагатай мэдээлэл, танилцуулгыг боловсруулж, удирдлагыг зохих мэдээллээр ханган ажилласан. Тайлант онд ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд харьяа төсөвт, төрийн өмчит байгууллагын нийт авлага 27.02 тэрбум төгрөг, богино хугацаат өр төлбөр 35.7 тэрбум төгрөг, орлого 105.6 тэрбум төгрөгийг хүлээн зөвшөөрч, үндсэн үйл ажиллагаа болон нийт /урсгал, хөрөнгийн/ зардалд 96.1 тэрбум төгрөг зарцуулж, нийт балансын хөрөнгө 512.8 тэрбум төгрөг, хуримтлагдсан үр дүн 41.7 тэрбум төгрөгөөр тайлагнасан болно. Мөн ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/1291 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. | |
| **Яамны стратегийн зорилт 7. Хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын стратегийн төлөвлөгөө, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж өгөх** | | | | | | | |
| **Зорилт 1. Яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх;** | | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо | 0 | 1 | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 176 | Арга хэмжээ 1.1. Яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргах; | - | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хяналт шалгалт хийсэн тоо | 2 | 1 | Монголын цахилгаан холбоо ХК-д 2024 оны А/59 дүгээр тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдаж 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөр гарсан дүгнэлт зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Харьяа болон салбарын нийт 7 байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 1 дүгээр улирлын байдлаар тайланг байгууллага тус бүрд хүргүүлсэн. | 100 |
| 177 | Арга хэмжээ 1.2. Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зөвлөмж бүхий тайлан гаргах; | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт зөвлөмж бүхий тайлангийн тоо | 0 | 1 | Тус яамнаас гадаадын зээл тусламж, гадны хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй Ухаалаг засаг 2 төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан дүгнэлт, зөвлөмжийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/520 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| **Зорилт 2. Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргах, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх;** | | - | Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо | **0** | **1** | **100** | |
| 178 | Арга хэмжээ 2.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө болон сайдын эрхлэх асуудлын хүрээний | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт | 0 | 30 | Яам болон харьяа, салбар байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, удирдлагын зөвлөлд танилцуулсан. Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын хэрэг Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудын төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж бүхий тайлан гаргах, аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх дүгнэлт зөвлөмж гаргах | | зөвлөмж бүхий тайлангийн тоо | | | системд 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдөр, 2025 оны биелэлтийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр тус тус тайлагнасан. Мөн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 03/501, 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 02/1643 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Түүнчлэн сайдын эрхлэх асуудлын хүрээний 9 байгууллагаас ирүүлсэн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тухай бүр албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн.<br>Мөн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 22 аймаг, нийслэлийн Засаг дарга тус бүрт болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр тус тус тайлагнасан. | |
| 179 | Арга хэмжээ 2.2. Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтад хамрагдах | - | Гаргасан тайлбар, баримтын тоо | 0 | 4 | "Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний биелэлт, Улсын хөрөнгө оруулалтын биелэлт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн биелэлтэд хамааралтай нэмэлт судалгаа, тайлбар баримтуудын хамтаар 2025 оны 01 дүгээр сарын 16-23-ны өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлэн ажилласан. Түүнчлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Монгол Улсыг 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2025 оны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийхэд голлох үүргийг гүйцэтгэж ажиллаа. | 70 |
| **Зорилт 3. Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчид тайлагнах;** | | - | Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо | **0** | **1** | **100** | |
| 180 | Арга хэмжээ 3.1. Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, | - | Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн тоо | 5<br>12 | 3<br>6 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг тайлант онд 10 удаа цахимаар, 2 удаа удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж албан бичгээр, тайлагнасан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагын зөвлөлийн хурлаар оруулах, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчид тайлагна | | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт зөвлөмж бүхий тайлангийн тоо | | | Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1396 дугаар албан бичгээр, 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/1040 дугар албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний биелэлтэд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1400 дугаар албан бичгээр, 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/1564 дугаар албан бичгээр, 3 удаа цахим системд тус тус тайлагнан.<br>Монгол Улсын 2025 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийг цахим болон цаасаар цаасаар 1 удаа 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/1564 дугаар албан бичгээр тайлагнасан.<br>Мөн Засгийн газрын 2025 он 43 дугаар тогтоолоор тайланг цахим системээр тайлагнах эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт орсон. | |
| **Яамны стратегийн зорилт 8. Эрсдэлд суурилсан салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн найдвартай ажиллагааг хангуулах** | | | | | | | |
| **Зорилт 1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах, үнэлэлт дүгнэлт өгч, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх;** | | - | **Шалгалт хийсэн объектын гүйцэтгэл /хувь/** | **-** | **100%** | **75** | |
| | | | **Албан шаардлагын хэрэгжилтийн /хувь/** | **28%** | **27%** | | |
| | | | **Хууль сахин мөрдөлт (хувь)** | **77,3%** | **79%** | | |
| 181 | Арга хэмжээ 1.1. Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй | - | Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугээр тогтоолоор баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлэгдсэн 171 объектод төлөвлөгөөт шалгалт хийнэ. | | Албан шаардлагын хэрэгжилтийн хув | 85 | 87 | 2024 оны А/63 дугаартай 2025 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай тушаалын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/03 дугаартай удирдамжийн хүрээнд нийт 171 объект төлөвлөснөөс 144 объектод төлөвлөгөөт шалгалт хийж төлөвлөгөөний хэрэгжилт 83,6 хувьтай байна. Учир нь Нийслэлийн хяналт шалгалтын газар, Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газар Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч томилогдоогүй, Булган аймгийн Засаг даргын тамгын газрын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч орон тоог хассантай холбоотой нийт 27 объектод хяналт шалгалт хийгдээгүй төлөвлөгөөний хэрэгжилт 83,6 хувьтай байна. Төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах улсын (ахлах) байцаагчийн 408 заалттай 144 албан шаардлага, 168 заалттай 31 зөвлөмжийг хүргүүлж, 63 заалттай 10 дүгнэлт үйлдэж хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилт-80 хувьтай, Зөвлөмжийн хэрэгжилт- 86 хувьтай байна. | |
| | | | Хууль сахин мөрдөлтийн хувь | 77,3 | 79 | | |
| 182 | Арга хэмжээ 1.2. Мэдээлэл харилцаа холбооны салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулна. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-д тусгагдсан ЦХИХХЯ/20250603027 дугаартай "Мэдээлэл харилцаа холбооны салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах" ажлын даалгавар баталж, "Гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай" 2025 оны А/191 дүгээр тушаал гарсан. "Куантум солюшн" ХХК-тай гэрээний төслийг боловсруулж хянагдсан боловч "Улсын төсвийн тодотгол"-оор хасагдаж тус арга хэмжээ хэрэгжихгүй болсон. | 50 |
| **Зорилт 2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт** | | | **Зөрчил арилгалтын хувь** | **74**<br>**-** | **79**<br>**50** | **70** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгалт хийх, холбогдох арга хэмжээг авах; | | | | | | |
| 183 | Арга хэмжээ 2.1. Гадаадын зээл тусламж, төсөл, хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ. | - | Зөрчил арилгалтын хувь | 74 | 79 | 1.Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугээр тогтоолоор баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/63 дугаартай 2025 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай тушаалын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/04 дугаартай удирдамжийн хүрээнд 89 объектод урьдчилан сэргийлэх шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах 169 заалттай 35 албан шаардлага, 110 заалттай 30 зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Албан шаардлагын хэрэгжилт-79 хувьтай, Зөвлөмжийн хэрэгжилт-83 хувьтай байна. 2.Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 09-00/06 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/197 дугаар албан томилолтоор ажиллуулах хугацаанд өөрчлөлт оруулах тухай тушаалын дагуу 2025 оны 2 дугаар сарын 10-аас 18-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Сэлэнгэ баг, Чандмань-Өндөр сумын Улаан асга баг, Эрдэнэбулган сум, Түнэл сум зэрэг газарт баригдсан үүрэн холбооны дахин дамжуулах станцын байр, харилцаа холбооны цамхаг, тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралтын байдалд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэн холбогдох зураг төсөл, стандарт норм дагуу хийж гүйцэтгэх талаар нийт 6 заалттай хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажилласан.<br>3.Харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангуулах, болзошгүй байгалийн гамшигт үзэгдэл, гэмтэл, саатал, ослоос урьдчилан сэргийлэх, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын аюулгүй байдал, ашиглалт үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангуулах зорилгоор харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй аж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуйн нэгж, байгууллагуудад 09-00-02/001/01 дугаар улсын ахлах байцаагчийн зөвлөмж гаргаж хүргүүлсэн. 4.Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/004 дугаартай Урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтын удирдамжийн хүрээнд Хятад улсын хөрөнгө оруулалтаар Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн захиалгатай Төв аймгийн Баян-Өнжүүл, Мөнгөн морьт, Баянжаргалан сумдын төвийг шилэн кабелиар холбох ажлын угсралт, суурилуулалтад Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын Улсын ахлах байцаагч нар хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, эрх зүйн акт гарган хангуулж ажилласан. | |
| 184 | Арга хэмжээ 2.2. Нийслэл, 21 аймгийн теле хяналтын системийн тоног төхөөрөмж, шугам сүлжээний зураг төсөл, угсралт, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ. | - | Зөрчил арилгалтын хувь | 0 | 50 | Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/05 дугаартай удирдамжийн хүрээнд 58 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж 78 заалттай 23 албан шаардлага, 94 заалттай зөвлөмж 18 хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Албан шаардлагын хэрэгжилт-67 хувьтай байна. | 100 |
| **Зорилт 3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм стандартын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх;** | | **19.8 Урсгал зардал** | **Албан шаардлагын биелэлтийн хувь** | **-** | **1** | **100** | |
| 185 | Арга хэмжээ 3.1. Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ. | - | Албан шаардлагын биелэлтийн хувь | 71 | 72 | 2025 оны төлөвлөгөөт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор гүйцэтгэлийн хяналт шалгалтыг улсын хэмжээнд 53 объектод хийж гүйцэтгэн 281 зөрчлөөс 218 зөрчлийг арилгуулан, 150000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч зөрчил арилгуулалтын хувь 77 хувьтай байна. | 100 |
| 186 | Арга хэмжээ 3.2. Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарын сургалт зохион байгуулна | 19.8 Урсгал зардал | Сургалтад хамрагдсан Улсын байцаагчийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 01 дүгээр сарын 02 өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-д тусгагдсан ЦХИХХЯ/20250603025 дугаар гэрээний дагуу Мэдээлэл, харилцаа холбооны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналтын улсын байцаагч нарын сургалт зохион байгуулах А/80 дугаар тушаалаар сургалтын арга хэмжээг зохион байгуулсан.<br>Аймгийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хяналт шалгалтын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Зэвсэгт хүчний жанжин штабын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын 31 улсын (ахлах) байцаагчдад 2025 оны 04 дүгээр сарын 23, 24, 25-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Сургалтаар хяналт шалгалтын арга хэлбэрийг илүү боловсронгуй болгох, хяналт шалгалтаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулж буй бэрхшээл, хүндрэлийг хөнгөвчлөх, хяналт шалгалтын давхардлыг арилгах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, аливаа аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулан иргэд, аж ахуйн нэгжүүдийн талархлыг хүлээсэн шинэчлэлт, өөрчлөлтийг хийж ажиллахыг улсын (ахлах) байцаагчдад чиглэл болголоо. | |

Төлөвлөгөөг хянасан:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд

Тэмдэг

*Төсвийн ерөнхийлөн захирагч*

.................................... /Э.БАТШУГАР/

(огноо)

2026.01.30

Төлөвлөгөө тайлагнасан:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Тэмдэг

*Төсвийн шууд захирагч*

.................................... /Б.МЯГМАРНАРАН/

(огноо)

2026.01.29.